

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 12 дугаар сарын 09-ний өдөр, Даваа гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-6

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 7-45

| | |
|--|-------|
| 1.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/ | 9-43 |
| 2.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/ | 44-45 |

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 12 дугаар сарын 09-ний өдөр
/Даваа гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 22 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 63.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 18 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Э.Бат-Амгалан, Х.Баттулга, Д.Ганбат, Б.Пүрэвдорж;

Эмнэлгийн чөлөөтэй: Л.Мөнхбаатар.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг өнөөдрийн хэлэлцэх асуудлын 3 дугаарт орсон ““Эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилт” хяналтын сонсголын тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний талаар” Байнгын хорооны тогтоолын төслийн хэлэлцүүлгийг хойшлуулах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 1

Бүгд: 14

92.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд өнөөдрийн хэлэлцэх асуудлын 4 дүгээрт орсон Санхүүгийн зохицуулах хорооны гишүүн, Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх асуудлын хэлэлцүүлгийг хойшлуулах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 1

Бүгд: 14

92.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Нэг.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд

О.Алтангэрэл, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилэг, мөн зөвлөлийн гишүүн А.Насандэлгэр, Гүйцэтгэх нарийн бичгийн дарга Б.Эрдэнэтулга, Шүүхийн сахилгын хорооны дарга Ц.Давхарбаяр, мөн хорооны Ажлын албаны дарга Д.Мөнхзориг, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, мөн комиссын Санхүү, хөрөнгө оруулалтын тасгийн дарга Б.Бадамсэрээжид, Монгол Улсын Ерөнхий аудиторовн орлогч З.Цэдэнжав, Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, мөн шүүхийн ерөнхий нягтлан бодогч А.Эрдэнэцэцэг, Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал Д.Эрдэнэчимэг, Улсын ерөнхий прокурорын Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм, Авлигатай тэмцэх газрын Тамгын газрын дарга З.Баасаням, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын Нарийн бичгийн дарга Г.Төгөлдөр, мөн комиссын Ажлын албаны дарга Л.Очирсүрэн, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Сонор, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Отгонцэцэг, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Д.Гантуяа, мөн газрын ахлах шинжээч Г.Базаргүр, Цагдаагийн ерөнхий газрын дарга Т.Сүхболд, мөн газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг, Санхүүгийн хэлтсийн дарга Н.Алтансүх, Хил хамгаалах ерөнхий газрын дарга Х.Лхагвасүрэн, мөн газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ц.Чойжилсүрэн, Архивын ерөнхий газрын дарга С.Энхбаатар, мөн газрын Санхүү, аж ахуйн хэлтсийн дарга Х.Цогтбаатар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Тэргүүн дэд дарга А.Намсаманд, мөн газрын Санхүү, үйлдвэр, хөрөнгө оруулалтын газрын дарга Т.Өнөртуяа, Эдийн засаг, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Энх-Од, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч У.Болдхүү, мөн газрын Санхүү, аж ахуйн хэлтсийн дарга Б.Өүлэн-Үжин, Шүүх шинжилгээний ерөнхий газрын дарга Ж.Буянбат, мөн газрын Санхүү, хангамжийн газрын дарга Х.Саранчимэг, Гадаадын иргэн, харьяатын газрын Захиргаа, удирдлагын газрын дарга И.Баатархүү, мөн газрын Санхүү, хангалт, үйлчилгээний газрын дарга Ж.Солонго, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах, мөн хүрээлэнгийн ахлах нягтлан бодогч Н.Уранчимэг, Хууль зүйн туслалцааны төвийн захирал Л.Уянга, мөн төвийн ахлах нягтлан бодогч Л.Болор-Эрдэнэ, Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн Техник ашиглалтын хэлтсийн дарга С.Баярболд, Дотоод хэргийн их сургуулийн Тэргүүн дэд захирал Д.Эрдэнэбаатар, мөн сургуулийн Санхүү, төлөвлөлтийн хэлтсийн дарга Ч.Лхагважав, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн захирал Н.Одонгуа, мөн эмнэлгийн Санхүү, хангамжийн албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Оюунтөгс нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх А.Болортуяа, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал нар байлцав.

Төсвийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч З.Цэдэнжав нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, С.Эрдэнэболд, Х.Баасанжаргал, Ц.Сандаг-Очир, О.Номинчимэг, Да.Цогтбаатар нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилэг, Шүүхийн сахилгын хорооны Ажлын албаны дарга Д.Мөнхзориг, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, Авлигатай тэмцэх газрын Тамгын газрын дарга З.Баасанням, Цагдаагийн ерөнхий газрын дарга Т.Сүхболд, Шүүх шинжилгээний ерөнхий газрын дарга Ж.Буянбат, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Тэргүүн дэд дарга А.Намсаманд, Дотоод хэргийн их сургуулийн Тэргүүн дэд захирал Д.Эрдэнэбаатар, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн захирал Н.Одонгуа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, С.Эрдэнэболд, Х.Тэмүүжин, М.Нарантуяа-Нара, Ц.Сандаг-Очир, О.Алтангэрэл, Д.Цогтбаатар, Ж.Алдаржавхлан нар үг хэлэв.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдийн гаргах зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэх тул хуралдаан 16 цаг 21 минутаас 17 цаг 49 минутад түр завсарлав.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Д.Цогтбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нарагийн гаргасан, Төслийн хавсралтын Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Дотоод хэргийн их сургуулийн 2025 онд нэмэгдэх орон тоог 30 хувиар бууруулж, Хууль зүй, дотоод хэргийн сайдын тоног, төхөөрөмжийн санхүүжилтийг 21,2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 6
Бүгд: 16
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, Төслийн хавсралтын Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын хөрөнгө оруулалт, их засварын зардлыг 9,8 тэрбум төгрөгөөр бууруулж, мөн дүнгээр Хууль зүй, дотоод хэргийн яамны норматив зардлыг нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргалын гаргасан, Төслийн хавсралтын Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн санхүүжилтийг 991 сая төгрөгөөр бууруулж, Авлигатай тэмцэх газрын томилолтын зардал 533,2 сая төгрөг, хангамж, бараа материалын зардал 112,6 сая төгрөг, хөрөнгийн зардал 345,4 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 6
Бүгд: 16
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргалын гаргасан, Төслийн хавсралтын Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн санхүүжилтийг 620,5 сая төгрөгөөр бууруулж, Монгол Улсын Ерөнхий прокурорын томилолт, зочны зардал 420,5 сая төгрөг, бичиг хэргийн зардал 200,5 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдын гаргасан, Төслийн хавсралтын Сангийн сайдын хөрөнгө оруулалт, их засварын зардлыг 5.6 тэрбум төгрөгөөр бууруулж, Цагдаагийн ерөнхий газрын томилолт, бичиг хэргийн зардал 2 тэрбум 900 сая төгрөг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын томилолт, бичиг хэргийн зардал 245 сая төгрөг, Хил хамгаалах ерөнхий газрын байр ашиглалтын зардал 1 тэрбум төгрөг, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн татаас санхүүжилт 920 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 9
Бүгд: 16
43.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

6.Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн гаргасан, Төслийн хавсралтын Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын хөрөнгө оруулалтын зардлыг 4 тэрбум 55 сая төгрөгөөр бууруулж, мөн дүнгээр Шүүхийн ерөнхий зөвлөлийн хөрөнгө оруулалтын зардлыг нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг үг хэлэв.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 10
Бүгд: 16
37.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 8
Бүгд: 16
50.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 18 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал байлцав.

Нэг.Зөрчлийн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хоёр.Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Гурав.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Төслийн заалтуудтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Тогтоолын төслийг заалт бүрээр хэлэлцэж дууслаа.

Дөрөв. “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Төслийн заалтуудтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Тогтоолын төслийг заалт бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 18 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 30 минут үргэлжилж, 22 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 72.7 хувийн ирцтэйгээр 18 цаг 16 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 12 дугаар сарын 09-ний өдөр,
Даваа гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
14 цаг 18 минут.

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Цогтбаатар: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг дэвшүүлье. ХЗБХ-ны 2024 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн хуралдааныг нээж байна. Байнгын хорооны хуралд ирсэн Хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Ирц, хуралдааны ирц Д.Цогтбаатар, Ж.Алдаржавхлан гишүүн, Х.Баасанжаргал гишүүн, Мөнхбаатар гишүүн, Л.Мөнхбаатар гишүүн чөлөөтэй байгаа, М.Нарантуяа-Нара гишүүн ирсэн байна, О.Номинчимэг гишүүн ирсэн байна, У.Отгонбаяр гишүүн ирсэн байна, П.Сайнзориг гишүүн ирсэн байна, Ц.Сандаг-Очир гишүүн ирсэн байна, Л.Соронзонболд гишүүн ирсэн байна, Х.Тэмүүжин гишүүн ирсэн байна, Г.Уянгахишиг гишүүн ирсэн байна, Да.Цогтбаатар гишүүн ирсэн байна, С.Эрдэнэболд гишүүн ирсэн байна, сая Одонтуяа гишүүн орж ирж байна С.Одонтуяа. Ингээд ирц 63,6 хувьтайгаар бүрдсэн байна. Ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдөр хэлэлцэхээр төлөвлөгдсөн бол 4 асуудал байна. 1 дүгээр асуудал Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд Засгийн газар 2024 оны 12 дугаар сарын 4-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлсэн байгаа, хүргүүлнэ. 2 дугаар асуудал бол Монгол Улсын төсвийн 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, Засгийн газарт чиглэл өгөх тухай, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслүүд. 3 дахь асуудал Байнгын хорооны тогтоолын төсөл. Энэ эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх, хүний эрхийн хэрэгжилт хяналтын сонсголын тайланг явуулсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай асуудал байгаа. 4 дэх асуудал нь Санхүүгийн зохицуулах хорооны гишүүн, Санхүүгийн зохицуулах хорооны хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх тухай асуудал гэсэн ийм 4 асуудал байна.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу, нэрсээ өгнө үү? Эрдэнэболд гишүүнээр тасаллаа. Биш, хэлэлцэх эсэхээ ярьж байна. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Даргаа баярлалаа. Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Хэлэлцэх асуудлын 3 дээр байгаа Эрүүдэн шүүх, хүнтэй хүнлэг энэрэнгүй бус харьцах

эрхийн хэрэгжилтийн сонсголын танилцуулгыг 1 долоо хоног хойшлуулъя гэж бодож байна. Энэ удаад төсвийн асуудал энэ долоо хоног бүтэн явж байна. Байнгын хороогоороо энэ асуудлыг нэг фокус өгөөд, дагаж гарах шийдвэрийн төслүүд дээрээ гишүүд маань нухацтай хандаад, шаардлагатай тохиолдолд Байнгын хорооныхоо түвшинд Улсын Их Хуралд танилцуулга хийх үү, үгүй юү гээд юмнууд ярилцах учраас энэ удаад хойшлуулаад, дараа долоо хоногийн Байнгын хорооны хурлаар хэлэлцүүлье гэсэн ийм горимын санал гаргаж байна. Дэмжиж өгөхийг хүсье. Хэлэлцэх асуудлын 3 дугаар асуудал.

Д.Цогтбаатар: Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбоотой асуудал, эрүүдэн шүүхтэй холбоотой асуудал байна. Эрдэнэболд гишүүний микрофоныг өгье.

С.Эрдэнэболд: Хэлэлцэх асуудалтай холбоотой 2, 3 зүйл. Нэгд нь болохоор хэлэлцэх асуудлын дотор байгаа тэр СЗХ-ны гишүүн томилох асуудлаар, сонгох асуудлаарх энэ зүйл дээр энэ Эдийн засгийн байнгын хороо, манай ХЗБХ-н дээр ийм 2 талд 2 өөр дэгээр мэдээллүүд яваад байгаа учраас энэ нөгөө ойлгомжгүй байгаа учраас долоо хоногийн хугацаанд хойшлуулаад, энийгээ дотоод ойлголцол, дэгээ нэгтгэх, зарчмын хувьд бол ойлголцолтой байх үүднээс хойшлуулах саналтай байна, долоо хоногоор хойшлуулах саналтай байна.

2 дугаарт нь хэлэлцэх асуудалд оруулах эсэх талаар өнгөрсөн долоо хоногийн баасан гаргийн, баасан гарагт буюу 5 дахь өдөр Сүхбаатарын талбай дээр зарим иргэд гарын үсэг цуглуулж, Хүний эрх ба эрүүл мэнд гэсэн сэдэв, тэр дотроо амьд явах эрх, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн асуудал зөрчигдөж байгаа. Энэ талаар хяналтын сонсгол явуулъя гэдэг ийм гарын үсэг цуглуулсан байна. Тэгээд онлайн буюу цахим petition-ээр санал нь хүрсэн. Иргэдийн зүгээс олон санал ирсэн байгаа учраас энийг манай ХЗБХ-н дээр хэрхэх талаар өнөөдөр ярилцах нь зөв болов уу гэж бодож байна.

Тэр 3 дугаарт нь тэр нэг Евро-Азийн хэлэлцээр гээд энэ сүүлийн үед энэ сошиалаар яваад, иргэдийг талцуулаад байгаа асуудал байгаа. Энэ ямар түвшинд явж байгаа юм бэ? Дээрээс нь энэ ХЗБХ энэ талаар авч хэлэлцэх үү үгүй юу, ярих уу үгүй юу? Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороогоор орж ирээгүй энэ асуудал дээр ер нь гишүүдийн байр суурийг хуралдааны дараа сонсох юм уу, ямар нэгэн байдлаар энийг авч үзсэн нь зөв юм уу гэсэн цаг үеийн байдалтай холбогдуулж гэсэн. Энэ 3 зүйл дээр санал оруулъя.

Д.Цогтбаатар: Энэ зарчмын, горимын саналаар санал хураах хэрэгтэй болно. Ерөнхийдөө энэ 3 дугаар асуудлаар Сайнзориг гишүүний гаргаж байгаа үндэслэл би бас үндэслэлтэй гэж үзэж байна. 4 дүгээр асуудал дээр бас энэ ойлголтын зөрөө явж байгаа. Би бол энэ асуудалд нээлттэй хандаж байгаа. Тэр 2 Байнгын хорооны баримталж байгаа зарчмыг би бол ер нь зөв юм болов уу гэж бодож байгаа. Өнөөдөр хүртэл явж ирсэн практикаас тэр маань өөр байгаа учраас бид энийгээ яг эрх зүйн үүднээсээ илүү нарийвчилж харах хэрэгтэй. Тийм учраас энэ дээр би Эрдэнэболд гишүүний гаргаж байгаа тэр саналыг бол бас дэмжиж байна. Гэхдээ бид санал хурааж байж л эндээ шийднэ.

Тэр амьдрах эрх, утааны асуудлаар би сая гадаадад томилолттой явж байсан, сошиалаар харж байсан. Эрдэнэболд гишүүн иргэдтэйгээ гараад уулзаж байна лээ. Хүний эрхийн дэд хорооны дарга гэдэг бол иргэдийнхээ дунд байх

ажил. Өөрөө яг гараад тэр иргэдтэйгээ үгийг нь сонсоод, дунд нь ороод ажиллаж байгааг би маш зөв гэж үзэж байна. Гарч ажиллаж байх хэрэгтэй. Тэр байтугай гэр хорооллуудаар яваад, яг тухайн газар дээрээ нөхцөл байдлууд ямар байгаа, тэр агаарын бохирдлын хэмжээ ямар байгаа эд нарыг ч гэсэн бид нарт мэдээлэл нь байгаа ч гэсэн та яг өөрөө очоод мэдээллээ гардан цуглуулах нь маш чухал гэж бодож байна. Энэ асуудлыг бид нэг их хойш тавилгүйгээр өнөөдөр бол яг шууд ингээд энд оруулах гэхээр бидэнд наад зах нь яг өнөөдөр тулгамдаад аваад ярих зөндөө асуудлууд надад жишээлбэл байгаа. Би өөрөө санаачилж байж энэ утааны сонсголыг бүүр шахсаар байгаад түрүүний парламентын үед хийлгэж байсан. Гэхдээ тэр бол өөр нөгөө том нүүрсний сонсгол дунд ороод явчихсан болохоор илүү бүдгэрчихсэн юм. Тэгэхээр энэ дээр бол энэ тусгайлан энэ асуудлыг авч үзэх нь би зөв гэж үзэж байгаа. Тэгээд энэ дээр нэлээн яг энэ хурлын дараа хэдүүлээ цуглаад, цаашдаа яг ямар арга хэмжээнүүд авч байж энэ хурал дээрээ авч орж ирж хэлэлцэх вэ энийгээ нарийвчилж ярих ёстой. Бэлтгэлгүйгээр бол Байнгын хороон дээр ярих боломжгүй байгаа. Тэгэхээр энийгээ тал талдаа бодъё.

Тэр Евро-Азийн юун дээр бол би ч мэдээлэлгүй байна. Тэгэхээр энэ эдийн засгийн хаана энэ асуудал маань яригдсан байгаа энийгээ ЗГ оруулж ирж Их Хурал дээр танилцуулах биз, тэгж байгаад явцгаая. Тэгээд энийг бол бүрэн мэдээлэлтэй болж байж бас ярих нь зөв гэж бодож байна.

Эхний Сайнзориг гишүүний гаргасан саналаар энэ хэлэлцэх асуудлын 3-д байгаа Байнгын хорооны тогтоолын төслийн талаарх асуудлыг хойшлуулах нь зөв гэсэн юугаар, хэлэлцэх асуудлаас хасаж, энийг хойшлуулах нь зөв гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 92,9 хувиар санал дэмжигдлээ. Тэгээд энд Сайнзориг гишүүнд нэг юу өгчихмөөр байна. Нэгэнт бид хойшлуулж байгаа юм чинь та энийгээ ер нь анхаараад, би ч араас нь дэмжээд, туслаад өгнө. Ондоо багтаагаад энэ асуудлаа харин гялс оруулах ёстой шүү.

4 дүгээр асуудлыг бэлтгэл хангатай хойшлуулъя, өнөөдрийн хэлэлцэх асуудлаас хасъя гэсэн саналыг дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 92,9 хувиар санал дэмжигдлээ. Энэ 2 асуудал тэгвэл өнөөдөр хэлэлцэх асуудлын дэс дарааллаас хасагдлаа. Хэлэлцэх асуудалтай холбогдуулан санал хураалт явуулж дууслаа. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

1 дүгээр асуудал Засгийн газар 2024 оны 12 дугаар сарын 4-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн хаана байна вэ? Би ажлын хэсгийг ямар ч гэсэн одоо энд ирсэн байдлаар танилцуулж байя. Л.Энхбилэг ШЕЗ-ийн дарга, А.Насандэлгэр ШЕЗ-ийн гишүүн,

Б.Эрдэнэтулга ШЕЗ-ийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга, Шүүхийн сахилгын хорооноос Ц.Давхарбаяр дарга Шүүхийн сахилгын хорооны дарга, Д.Мөнхзориг Шүүхийн сахилгын хорооны ажлын албаны дарга. Улсын дээд шүүхээс С.Заяадэлгэр дарга ирсэн байж байгаа, Д.Эрдэнэчимэг дарга ирсэн байгаа Шүүхийн сургалт, судалгаа мэдээллийн хүрээлэнгийн захирал, А.Эрдэнэцэцэг дарга Улсын шүүхийн ерөнхий нягтлан бодогч ирсэн байна. УЕПГ-аас С.Гансэлэм УЕП-ын туслах прокурор, Хэрэг эрхлэх газрын дарга, ХЭҮК-оос Д.Сүнжид дарга ирсэн байгаа Хүний эрхийн Комиссын дарга байгаа, Б.Бадамсэрээжид ХЭҮК-ын Санхүү, хөрөнгө оруулалтын тасгийн дарга, ерөнхий нягтлан бодогч, АТГ З.Баасанням АТГ-ын Тамгын хэлтсийн дарга, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс Г.Төгөлдөр Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын нарийн бичгийн дарга, Л.Очирсүрэн Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын Ажлын албаны дарга гэсэн ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ирсэн байна.

Хууль зүйн яамнаас ирсэн төлөөлөгчийг танилцуулъя. ХЗДХЯ-ны ТНБД Н.Мягмар, ХЗДХЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Д.Гантуяа, ЦЕГ-аас ЦЕГ-ын дарга Т.Сүхболд, ЦЕГ-ын Хуулийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Б.Батзориг, ЦЕГ-ын ерөнхий нягтлан бодогч бөгөөд Санхүүгийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Н.Алтансүх, ХХЕГ-аас ХХЕГ-ын дарга, хошууч генерал Х.Лхагвасүрэн, Хил хамгаалах ерөнхий газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, ерөнхий нягтлан бодогч, хурандаа Ц.Чойжилсүрэн, ШШГЕГ-аас ШШГЕГ-ын Тэргүүн дэд дарга бөгөөд Хорих ял эдлүүлэх албаны дарга, хурандаа А.Намсаманд, ШШГЕГ-ын Санхүү, үйлдвэр, хөрөнгө оруулалтын газрын дарга, хошууч Т.Өнөртуяа, ШШГЕГ-ын Эдийн засаг, төлөвлөлтийн хэлтсийн дарга, ахмад Б.Энх-Од, УБЕГ-аас УБЕГ-ын даргын албан үүргийн үүргийг түр орлон гүйцэтгэгч У.Болдхүү, Санхүү, аж ахуйн хэлтсийн дарга, шүүх шинжилгээний, Санхүү, аж ахуйн хэлтсийн дарга Б.Өүлэн-Үжин, Шүүх шинжилгээний ерөнхий газраас Шүүх шинжилгээний ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа Ж.Буянбат, Санхүү, хангамжийн газрын дарга Х.Саранчимэг, ГИХГ-аас ГИХГ-ын Захиргаа, удирдлагын газрын дарга И.Баатархүү, ГИХГ-ын Санхүү, хангалтын үйлчилгээний газрын дарга Ж.Солонго, Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн ахлах нягтлан бодогч Н.Уранчимэг, Хууль зүйн туслалцааны төвөөс Хууль зүйн туслалцааны төвийн захирал Л.Уянга, Хууль зүйн туслалцааны төвийн ахлах нягтлан бодогч Л.Болор-Эрдэнэ, Мэдээлэл шуурхай удирдлагын төвөөс Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн Техник ашиглалтын хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа С.Баярболд, АЕГ-аас АЕГ-ын дарга С.Энхбаатар, АЕГ-ын Санхүү, аж ахуйн хэлтсийн дарга Х.Цогтбаатар, Дотоод хэргийн их сургуулиас Дотоод хэргийн их сургуулийн Тэргүүн дэд захирал, цагдаагийн хурандаа Д.Эрдэнэбаатар, Дотоод хэргийн их сургуулийн Санхүү, төлөвлөлтийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Ч.Лхагважав, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгээс Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн захирал Н.Одонгуа, Санхүү, хангамжийн албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, ахмад Б.Оюунтөгс гэсэн бүрэлдэхүүнтэйгээр ажлын хэсэг энд ирсэн байна. Хуралд оролцож байна.

Сангийн яамнаас ирсэн төлөөллийг танилцуулъя. Сангийн яамнаас Сангийн яамны ТНБД, Сангийн сайд Жавхлан, Сангийн яамны ТНБД Жигжидийн Ганбат, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга

Бямбарагчаагийн Тэлмүүн, Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Ганболдын Золбоо, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Сонор, Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Сангийн яамны Хөгжлийн санхүүгийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Отгонцэцэг, Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох гэсэн бүрэлдэхүүнтэйгээр Сангийн яамнаас ажлын хэсэгт төлөөлөгчид оролцож байна. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулж дууслаа.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна. Болд даргын, Жавхлан даргын сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Баярлалаа. Эрхэм Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурал Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл болон дагалдах бусад хууль тогтоомжийн төслийг 24 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр хэлэлцэн баталсан. Үүний дараахан Монгол Улсын Ерөнхийлөгчөөс гадаад зах зээлийн тогтворгүй байдал, түүхий эдийн үнийн хэлбэлзлээс үүдэн 2025 оны төсөв үр ашигтай хэмнэлттэй, алдагддаггүй байх шаардлагатай гэсэн үндэслэлээр 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр бүхэлд нь хориг тавьсан. Улмаар Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэн хүлээн авч, алдагдалгүй төсөв батлах чиглэл өгсний дагуу ЗГ-аас Монгол Улсын 2025 онд төсвийн төслийг шинэчлэн боловсруулж, дахин өргөн барьсан.

Төсвийн зардлыг бууруулахад дараах зарчим баримталлаа. 1.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, ЭМД-ын сангаас санхүүжүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, нийгмийн халамжийн сангаас олгох хүүхдийн мөнгөн тэтгэмж, халамжийн тэтгэвэр, амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, асаргааны тэтгэмж, түүнчлэн төрийн албан хаагчийн цалин хөлс болон тэтгэвэрт гарахад нэг удаа олгох тэтгэмж, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж зэрэг өрхийн орлогыг дэмждэг төсвийн бүхий л зардлууд, мөн гадаад зээлийн үйлчилгээний төлбөр, мөн хуульд заасны дагуу Улсын Их Хурлын ХЗБХ-ноос төсвийг нь хянаж, жилийн төсөвт тусгахаар ирүүлсэн байгууллагууд болон ХЭҮК зэрэг урсгал зардлыг бууруулахгүйгээр хэвээр нь төлөвлөвөө.

2.Төсөвт байгууллагын үйл ажиллагааны зарим зардлыг дараах байдлаар 10-аас 100 хувь бууруулна. Салбар харгалзахгүйгээр бүх төсөвт байгууллагуудын тавилга, эд хогшил худалдан авах, сургалт, семинар, хурал зөвлөгөөн хийх, биеийн тамирын уралдаан тэмцээн зохион байгуулах, гэрээт ажилтан ажиллуулах, дуудлагын автомашин хөлслөх, зөвлөл, хороо, комиссын гишүүний урамшууллын зардлыг 100 хувь бууруулах.

Б.Соёлын эрхийн бичиг, Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих, Кино урлагийг дэмжих сан, засаг захиргааны нэгж, төрийн захиргааны байгууллагын үр

дүнгээр шагнах урамшуулах, идэвхтэй амьдралын хэвшлийг дэмжих болон эрүүл идэвхтэй амьдрал хөтөлбөрийн зардлыг 100 хувь бууруулна.

В.Эрүүл мэнд болон тусгай чиг үүргийн байгууллагаас бусад бүх байгууллагын тээвэр шатахууны зардал, төрийн өндөр дээд айлчлал болон гаднын өндөр түвшний зочин төлөөлөгч хүлээн авахаас бусад гадаад албан томилолтын болон зочин төлөөлөгч хүлээн авах зардал, эрүүл мэнд, боловсрол, батлан хамгаалах, гадаад харилцаа, ХЗДХ-ийн салбараас бусад салбарын дадлага, бэлтгэл, сургуулилт хийх зардал, бүх шатны төсвийн байгууллагын дотоод албан томилолт, бичиг хэргийн зардал, багаж, техник хэрэгсэл худалдан авах зардлыг тус тус 50 хувиар бууруулах.

Г.Дээр дурдсан 50-аас 100 хувь бууруулах зардлуудаас гадна байр ашиглалтын зардал, хангамж, бараа материал, нормативт эм бэлдмэл, нормын хувцас, хоол, урсгал засвар, хөдөлмөрийн хамгааллын хэрэгсэл, төрийн болон хувь хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас, шилжүүлэг, эргэж төлөгдөх зээл, бараа, үйлчилгээний бусад зардал, төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх арга хэмжээ, боловсролын тэтгэлэг, авто зам, гүүрэн байгууламжийн засвар, ашиглалтын зардлыг 10 хувиар тус тус буурууллаа.

3.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан төсөл, арга хэмжээнээс гэрээ байгуулсан, ажлыг нь эхлүүлсэн төслүүдийг аль болох яаралтай дуусгая.

4-д нь хэрэв гэрээ байгуулаагүй, ажил эхлээгүй улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг эрэмбэлж хойшлуулъя.

5.Зарим эх үүсвэр, ТЭЗҮ, зураг, төсөв, тоног төхөөрөмжийн санхүүжилтийг бууруулж, хэлэлцээрийн шатад байгаа төслийг хойшлуулна.

Гадаад зээлийн ашиглалтыг бууруулж, хэлэлцээрийн шатад байгаа үндэсний хиймэл дагуулын төсөл болон бусад төслийн зээлийн ашиглалтыг хойшлуулна. Хавдар судлалын үндэсний төв, 2 хөрөнгө оруулалтыг нэмж тусгалаа.

Нэгдсэн төсвийн нийт орлогыг төсвийн хөрөнгө оруулалт, зарлагын бууралттай холбогдуулан 394,8 тэрбум төгрөг буурахаар тооцлоо. Ингэснээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн дүн 33,5 их наяд төгрөг буюу ДНБ-ий 35, нийт зарлага ба цэвэр дүн 33,5 их наяд төгрөг буюу дотоодын бүтээгдэхүүний 35 хувьд хүрч, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл алдагдалгүй болж, суурь тэнцэл ДНБ-ий 3,3 хувийн ашигтай болохоор байна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хууль хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн 11 хуулийн төсөл, 4 Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа. Эдгээр хууль тогтоомжийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Цогтбаатар: Жавхлан сайдад баярлалаа. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдэд хийсэн аудитын дүгнэлтийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч З.Цэдэнжав танилцуулна. Хэддүгээр микрофон вэ? 7 дугаар микрофон өгье.

З.Цэдэнжав: Монгол Улсын Их Хурлын ХЗБХ-ны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын байгууллага Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын ЗГ-аас 2024 оны 12 дугаар сарын 4-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитыг гүйцэтгэж, аудитын тайлан, дүгнэлтийг Улсын Их Хурал, Засгийн газарт хүргүүлсэн болно.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс гадаад зах зээлийн тогтворгүй байдал, түүхий эдийн үнийн хэлбэлзлээс үүдэн 2025 оны төсвийг үр ашигтай, хэмнэлттэй, алдагдалгүй батлах шаардлагатай гэсэн үндэслэлээр 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр бүхэлд нь хориг тавьсан нь ач холбогдолтой болсон байна. Иймд Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар Ерөнхийлөгчийн хоригийг 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр хэлэлцэн хүлээн авч, алдагдалгүй төсөв батлах чиглэл өгсний дагуу Монгол Улсын ЗГ-аас Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг шинэчлэн боловсруулж, дахин өргөн барьсан байна.

Тус аудитын зорилго нь Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөл нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангасан эсэх, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх зорилтод нийцсэн эсэхийг хянаж дүгнэхэд чиглэсэн бөгөөд чиглэсэн байна. ЗГ-аас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд Байнгын хороонд, тус Байнгын хороонд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийг дараах байдалтай төлөвлөжээ. 2025 оны төсөвт төвлөрүүлэх орлогыг ХЗДХ-ийн сайд 81,2 тэрбум төгрөг, ШЕЗ-ийн дарга 0,5 тэрбум төгрөг, ингээд 81,7 тэрбум төгрөгөөр, ХЗДХ-ийн сайдын төсөвт төвлөрүүлэх орлогыг 0,1 тэрбум төгрөгөөр бууруулсан байна.

Төсөвт, төсвийн зардлыг 2025 оны төсвийн төсөлд ХЗДХ-ийн сайд 1 их наяд 758,1 тэрбум төгрөг, Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч 31,9 тэрбум төгрөг, ШЕЗ-ийн дарга 339,9 тэрбум төгрөг, Шүүхийн сахилгын хорооны дарга 6,5 тэрбум төгрөг, УЕП 157,9 тэрбум төгрөг, Хүний эрхийн Комиссын дарга 14,9 тэрбум төгрөг, АТГ-ын дарга 56,9 тэрбум төгрөг, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дарга 1,3 тэрбум төгрөг нийт 2 их наяд 367,4 тэрбум төгрөг байхаар тооцсон бөгөөд өмнөх 25 оны суурь төсвөөс ХЗДХ-ийн сайдын зардлыг 77,6 тэрбум төгрөгөөр, Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгчийн зардлыг 1 тэрбум төгрөгөөр, ШЕЗ-ийн даргыг 1 тэрбум төгрөгөөр, ХЭҮК-ын даргын зардлыг 0,7 тэрбум төгрөгөөр, АТГ-ын даргын зардлыг 1,3 тэрбум төгрөгөөр, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комиссын төсвийг 0,1 тэрбум төгрөгөөр тус тус бууруулж, ШЕЗ-ийн даргын төсвийг 20,2 тэрбум төгрөгөөр, Шүүхийн сахилгын хорооны төсвийг 0,1 тэрбум төгрөгөөр, Монгол Улсын ЕП-ын төсвийг 12,2 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, нийт дүнгээр 48,2 тэрбум төгрөгөөр зардлыг бууруулсан байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн төсөл нь урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын үзэл баримтлал, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцсэн боловч дараах асуудлыг анхаарах нь зүйтэй байна.

Үүнд 1 дүгээрт, гадаад хүчин зүйлийн нөлөөлөл уул уурхайн салбарын голлох нэрийн бүтээгдэхүүний эрэлтээс шалтгаалж, нүүрсний экспорт төлөвлөсөн хэмжээнд хүрэхгүй тохиолдолд зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэр дутагдах, орлого тасрах эрсдэлийг тооцох шаардлагатай.

2. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-аас 27 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг төсөвт өөрчлөлт оруулах бүрд нэмж өөрчилж байгаа нь төсвийн удирдлагын зарчим, сахилга батыг алдагдуулж, дунд хугацааны төсвийн төлөвлөлтийн ач холбогдлыг бууруулж байна.

3. Цахим систем болон ТЭЗҮ боловсруулах ажлын өртөг зардлыг тооцож төлөвлөх, хянах, хэрэгжүүлэх, хүлээн авахтай холбоотой зохицуулалт, жишиг үнэ, заавар журам хангалтгүй байгаа нь төсөвт өртгийг үндэслэлтэй тооцож, үр ашигтай төлөвлөхөд сөргөөр нөлөөлж байна.

4. Төсвийн урсгал зардлыг хумьж, зарим хэрэгжиж эхлээгүй хөтөлбөр, үйл ажиллагааг зогсоохоор төлөвлөсөн нь төсвийн зарлагын ДНБ-д эзлэх харьцааг бууруулсан сайн талтай боловч зардлыг хэт механикаар хассан нь 2025 онд төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг бууруулах, тоо хэмжээг хумих эрсдэл үүсэх магадлалтай байна.

5. Төрийн үйлчилгээг илүү цомхон бүтэцтэй, ухаалаг байдлаар үзүүлэхийн тулд төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх тогтолцооны өөрчлөлтийг хууль, эрх зүйн орчинд бүрдүүлэх шаардлагатай байна.

6. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 12-т төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаанд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аудитын хуулийн этгээдээр аудит хийлгэж болно. Тухайн санхүүгийн жилд аудит хийлгэх төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт болон аудит хийх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах этгээдийг ЗГ тогтооно гэсэн нь Улсын Их Хурлын ЗГ-т тавих хяналтын зарчмыг алдагдуулахаас гадна Монгол Улсын Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гарсан хууль тогтоомжтой нийцэхгүй байна. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Цогтбаатар: Цэдэнжав даргад баярлалаа. Хууль санаачлагчаас болон Байнгын хорооны өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхий захирагчдаас асуулт асуух гишүүд байна уу, нэрсээ өгнө үү? Номинчимэг гишүүнээр тасаллаа. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Баярлалаа. Бүгдэд нь энэ өдрийн мэндийг хүргэе. Би Төрийн хэмнэлтийн хуулийн нэг заалтыг эхлээд уншаадахъя. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад дараах зүйлийг тусгахыг хориглоно гээд. 13.1.4 байгаа орон нутгийн нийтийн эзэмшлийн зам талбай, олон нийтийн соёл, амралтын хүрээлэн, хаягжуулалт, гэрэлтүүлэг, тохижилт гээд. Энэ дээр түрүүчийн буцдаг төсөв дээр батлуулж байсан Сүхбаатар

аймгийн төв дээр баригдаж байсан энэ соёл амралтын хүрээлэн 13 тэрбум төгрөгийн нийт өртөгтэй энэ зүйл хасагдаж орж ирсэн үү үгүй юу? Сангийн яам хуульд нийцүүлсэн үү, үгүй юу энийг хэлж өгөөч. Ийм хуульд нийцээгүй жишээ нь саналууд хураагдаад явчихдаг, гарсан шүү дээ дэмжигдсэн гэдэг байдлаар ч юм уу ингээд явчаж байна. Энийг 1 дүгээрт хариулж өгөөч.

2 дугаарт ер нь энэ улсын төсөв гэдэг бол хүний эрхийг хангах томоохон бодлогын бичиг баримт. Гэтэл бид ингээд механикаар зардлуудыг нь хасаад, хуульд заасан чиг үүргээ гүйцэтгэх энэ нөхцөл байдлууд энэ хууль сахиулах байгууллага дээр ирэх жилүүдэд яах бол доо? Яг энэ дээр хэн хариулах вэ? Хууль зүйн сайд хариулах уу? Та яг энэ салбар байгууллагуудын хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд хангалттай төсөв байна уу? Хоригдол алдвал яах вэ? Гэмт хэрэгтэй тэмцэх энэ гэдэг юм уу, өнөөдрийн түвшнээсээ гэмт хэргийн илрүүлэлт нэмэгдэж чадах уу? Эргээд энэ тодорхой энэ гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил дээр ахиц гарч чадах уу? Энэ бүх ажлууд чинь ингээд энэ төсөв мөнгөтэйгөө шууд уялдана.

Энэ сая Үндэсний аудитын газрын дүгнэлтэд тодорхой гарч байна шүү дээ. Механикаар ингээд хасаж байгаа нь энэ чиглэлийн асуудал хүндэрч магадгүй гээд. Тэгэхээр бид энэ ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрөө хэрэгжүүлэх чиглэлд анхаар гэдгийг Ерөнхийлөгчийн хориг уг нь тусгаж өгсөн. Энд чинь бид хүний эрхийг хангах, дээдлэх чиглэл рүү явна гэххээд яг эсрэгээр нь төсвийг оруулж ирэхдээ энэ чиглэлийн доголдол үүсэхээр сая дүгнэлтэд гарч байгаа нь туйлын харамсалтай юм. Тэгэхээр ХЗДХ-ийн сайд хариулна биз.

2 дугаарт энэ хэмнэлтийг нэг зарим байгууллагуудаас хийе. ХЭҮК-ын дэргэд энэ эрүүдэн шүүхийн эсрэг байгууллага маань тусдаа байр хөлсөлчихсөн явж байх юм. Би энэ ХЭҮК-ын хуулийг би өөрөө бичсэний хувьд ийм зүйл хийгээгүй. Харьцангуй бие дааж ажиллах бололцоог нь бүрдүүлж, урьдчилан сэргийлэх ажилтай явдаг энэ эрүүдэн шүүхийн комисс сүүлдээ бүүр хяналт шалгалт хийдэг бүүр тусдаа байртай гарна, тусдаа байгууллага болно гээд явж байх юм. Энэ юу болж байгаа юм бэ? Яагаад ийм 2 байр хөлслөөд байгаа юм бэ? 1 байрандаа яагаад багтаж шингэхээ больчихсон юм бэ? Тэгээд энэ хэмнэж байгаа зардлыг нь ядаж өөр зүйлд хэрэгтэй зүйлд нь зарцуулмаар байна шүү дээ. Тэгэхээр энийг би бас асуумаар байна.

Ингээд ер нь энхийг сахиулах ажиллагаа дээр бид бас амлалт өгөөд, 170 хүний баг бүрэлдэхүүнтэй цагдаагийн бие бүрэлдэхүүнийг илгээнэ гээд бэлтгэл ажилдаа орж байтал энэ төсвийг нь хасаад хаячихсан. Нөгөө НҮБ-ын цагдаагийн комиссар атташетай байгуулсан.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Тэгье микрофон, Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Тэгэхээр энэ дээр хөрөнгө оруулалт байхгүйгээс энэ НҮБ-ын өмнө хэлсэн амлалтдаа бид хэд хүрч чадахаа болилоо. Шүүх шинжилгээний байгууллагын тоног, төхөөрөмж зардал дээр хэчнээн төгрөг орж ирж байгаа вэ? Шатахууны зардал, бичиг хэргийн зардлыг жишээ нь хууль сахиулах байгууллага дээр угаасаа хүрэлцдэггүй зардлыг 50 хувь бууруулчихаар дуудлагадаа явж амжих уу? Түүн дээр 2 хүн гэмт хэрэг 1 нь хохирогч болчихоод, 1 нь гэмт хэрэг үйлдчихээд байхад очиж чадах уу? Энэ ингээд их сонин юм үүсэх нь дээ.

2 дугаарт энэ төрийн буруутайгаас хохирол барагдуулах тэр нэг буцдаг төсөв дээр 21 тэрбум сонсогдоод, буцсан. Нийт яг 70, 80 тэрбумын төрөөс авлагатай хүмүүс байгаа. Цаана нь хүний эрх зөрчигдөөд явж байгаа шүү дээ. Энэ жишээ нь хэчнээн төгрөг төсөвлөж орж ирсэн бэ? Ямар хохирлууд байдаг юм бэ энийг Алтангэрэл нэг сайд хэлчхээч? Тэгэхгүй ингээд иргэд ерөөсөө ойлгохгүй байгаа байхгүй юу. Тэгээд улс төрчид нь ойлгодоггүй. Цаана нь ингээд төрийн буруутайгаас иргэд хохироод л байгаад байдаг.

Дотоодын цэргээс бас хасчихжээ. Ундны усны хамгаалалтаас эхлээд, бид хэд ундны усыг л нэг хордуулах гэдэг юм уу, аюулгүй байдал хангахад нийтээрээ л гамшиг.../минут дуусав/

Д.Цогтбаатар: ХЭҮК-ын дарга аль микрофон дээр сууж байна вэ, би харахгүй байна. Эхлээд Алтангэрэл сайдад микрофоныг нь өгье.

О.Алтангэрэл: Сайнзориг гишүүнийхээ асуултад тодорхой, тодорхой хариулаад явчихъя. Энэ ХЗДХ-ийн салбарын байгууллагуудын төлөөлөл нь энд сууж байна. Бид бүгдээрээ мэднэ. ХЗДХ-ийн салбарын байгууллага ер нь бусад агентлаг байгууллагуудаас хамгийн их дотоод томилолттой. Цагдаа бол байнга л явж байдаг ажил. Шүүх шинжилгээний алба хэргийн газар яваад л очно. Тэгээд маш их цаас хэрэглэдэг. Тэгээд бичиг хэргийн зардал шууд автоматаар 50 хувь, тэгээд дотоод томилолтын зардал автоматаар 50 хувь гээд ингээд хасчихсан. Тэгээд дээрээс нь дахиад орон тоотой холбоотой зүйл ярьж байгаа юм. Манай салбарт мянга гаруй орон тоо байна. Энэ хэтэрхий нэмэгдэж байна гэж. Бүхлээр нь сонсохоор ингээд аргагүй тэгж санагдана л даа. Гэтэл энэ чинь яг задлаад үзэхээр жишээлбэл сая Сайнзориг гишүүний хэлдэг тэр ус хангамж ЗГ-ын тогтоолоор энэ ус хангамжийн эх үүсвэрийн Яармаг насос, Чингэлтэй насос, Хайлааст насос, Чингис хотын ус хангамжийн эх үүсвэр, Мөрөн хотын ус хангамжийн эх үүсвэр, Даланзадгад, Ховд гээд ингээд олон эх үүсвэрүүдийг хамгаал гээд ЗГ-ын тогтоол нь гарчихсан. Тэгээд ЗГ-ын тогтоолоо хэрэгжүүлээд хамгаалъя гэхээр орон тоо хүрдэггүй.

Дахиад ингээд задлаад харвал энэ манай цагдаагийн байгууллага дотор халаасны хулгайтай тэмцье гээд энэ гар утасны хулгай их байна, автобусанд хулгай их байна гээд бүх төрлийн хүмүүс иргэд гомдож байна. Тэгээд энд нь 19 хүн нэмье, дүүргийн цагдаагийн хэлтсүүдэд 1 сэтгэл зүйч 8-хан хүн нэмье, эрүүлжүүлэх саатуулах байрны эмчийн 3 орон тоотой газруудад 9-ийг нэмье гээд дандаа өөрсдийнхөө хэрэгцээ шаардлагын орон тоонуудыг тавиад энэнээс бүүр хамаагүй их байсан. Сангийн яаман дээр хасаж тануулсаар байгаад ороод ирэнгүүт, одоо дахиад манай энэ орон тоог хасах зүйл ярьж байна. Өнөөдөр 1 шүүхийн шийдвэр гүйцэтгэгч оногдож байгаа гүйцэтгэх хуудасны тоо 270 байна. 270 гүйцэтгэх хуудсыг ажлын 20 хоногт, 21 хоногт тэр шийдвэр гүйцэтгэгч хүрч чаддаггүй. Энийг жоохон нэмье гэсэн.

Дахиад энэ эрүүгийн хэргийн шийдвэр гүйцэтгэгчид буюу нөгөө Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомжийн дагуу хорихоос төрлийн өөр ял хэрэглээд гар, хөлд нь цахим бугуйвч зүүгээд байгаа иргэдийг чинь хянадаг 1 шийдвэр гүйцэтгэгчийн, 1 хянах хүний тоо 350 хүн болчихож байгаа юм. Үгүй ээ энэ чинь физикал дийлэхгүй байгаа байхгүй юу бодитоороо биеэрээ энэ хянаж. Тэгээд орон тоогоо нэмье гээд ингээд орж ирж байгаа юм. Энэ маягаар хүний эрхийг өнгөрсөн жилүүдэд хариуцлагатайгаар хэлэхэд 2001 оноос 23 энэ ХЭҮК хүний эрхийн

илтгэл гаргасан. Илтгэл болгонд эрүүдэн шүүхтэй холбоотой асуудал, илтгэл болгонд наад албан хаагчдын чинь дутагдал хүрэлцээгүй, хууль сахиулах байгууллагын албан хаагчдын чинь хүрэлцээгүй байдал эргээд эрүүдэн шүүлт болон хууль сахиулах үйл ажиллагааны чанарт чинь муугаар нөлөөлөөд, хүний эрхийг хангахад чинь муугаар нөлөөлнө шүү гэж хэлдэг. Ингээд энэ хүний эрхийг хангах гэж байгаа үйл ажиллагаанд голчлон оролцдог хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагаа яг энэ зардал танаснаар доголдолд орж байна.

Тэр төрийн буруутай ажиллагааны улмаас би нарийн тоо нь хэд билээ Ганаа дарга? 21,2 тэрбум төгрөг тавьсан. Нийтдээ бол 70-аад тэрбум төгрөгийн авлагатай хүмүүс байгаа. Ингээд хүлээгээд л яваад байдаг, тэр нь хэзээ ч барагддаггүй. Энийгээ нэг гүйцэд тавиад, барагдуулаад, төр буруутай албан тушаалтнуудаас эргээд авдаг энэ механизмаа хийхгүй жилийн жилд ингээд явж байдаг. Гэх мэтчилний маш хүндрэлтэй асуудлууд байгаа гэдгийг Сайнзориг гишүүний асуултад хариулж хэлье.

Д.Цогтбаатар: 9 дүгээр микрофон Сүнжид дарга.

Д.Сүнжид: ХЗБХ-ны дарга, гишүүдийн амгаланг айлтгая. Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Нийтдээ 2025 онд 188 сая төгрөгийг түрээсэнд төсөвлөсөн. Тэгээд үүнээс 78 сая нь эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа хариуцсан нэгж нь тусдаа байрны түрээс төлнө гэдгээр төсөвлөсөн байгаа. Уг нь хамтдаа байсан 600м², ЗГ-ын 12 дугаар байранд 600м² ашигтай талбайтай байр түрээсэлж байгаад тэгээд зай талбай хүртээмжгүй байна, үйл ажиллагаа явуулах боломжгүй байна гэдэг үүднээс энэ оны 11 сарын 1-нээс ТӨБЗГ луу бичиг явуулаад зөвшөөрөл аваад метр квадратыг нь 32 мянгаар түрээсэлж байгаа юм. Ингээд жилийн 78 сая төгрөг түрээслэхээр ийм байдлаар ингэж төсөвлөөд байгаа юм.

Д.Цогтбаатар: 2 дугаар микрофон цагдаа, дараа нь шүүх шинжилгээний газар бэлдэж байгаарай. Тэрний дараа энэ хүүхдийн хорихын асуудлаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар аль микрофон дээр байна вэ бас бэлдэж байгаарай. 2 дугаар микрофон.

Т.Сүхболд: ХЗБХ-ны дарга, гишүүдийн энэ өдрийн амрыг эрье. ЦЕГ-ын дарга Сүхболд. Манайх анх 2019 орон тоо нэмүүлье гээд явуулсан. Тэр маань Сангийн яаман дээр очиж танагдаад 863 орон тоо болсон. Бид ЗГ-ын 2011 оны 153 дугаар тогтоолоор бол одоо 6096 орон тоо дутуу байгаа манайх. Тэгээд бид бол 863-гаа л нэмүүлье гэсэн юм. Энэ ямар орон тоо дутуу байгаа вэ гэхээр хэсгийн төлөөлөгч цагдаа гэхэд 344 дутуу, эргүүлийн, эрүүгийн төлөөлөгч цагдаа 183, хэсгийн байцаагч гэхэд 226, хүүхдийн байцаагч 234, хэв журмын эргүүл 1422, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах.../минут дуусав/

Д.Цогтбаатар: 2 дугаар микрофон гүйцээгээд өгье.

Т.Сүхболд: Үүрэг бүхий алба хаагч 2588 дутуу байгаа. Энэ нөгөө ЗГ-ын тогтоолоор 4 мянган хүн тутамд нэг хэсгийн байцаагч байна, 50 мянган хүн тутамд нэг хэлтэс байна гэдэг энэ тогтоолоор. Бид бол заавал ч үгүй энэ 6096 орон тоо авъя гээгүй. Бид аль болохоор л нөхөж яваа. Жишээлбэл 24 хийгээд 72 цаг амрах ёстой алба хаагчаа 48 цаг амраагаад л, 72 дэх цаг дээр нь дахиад л эргүүлд гаргаж байгаа. Замын цагдаагийн 8 цаг ажиллаад 24 цаг амрах ёстой алба хаагчийг 16

цаг ажиллаад л эргүүлд нь гаргаж байгаа. Яг энэ мэтчилэнгээр л явж байгаа. Гэхдээ бид зайлшгүй шаардлагатай ЗГ-ын тогтоолтой, дээрээс нь энэ объектууд хамгаалах, дээрээс нь нөгөө 3 ээлжтэй байгаа эмч нараа 4 болгоё, 24, 72 болгоё гэсэн энэ саналуудаа л өгсөн.

Д.Цогтбаатар: Жавхлан сайдын микрофоныг өгье. Тэгээд дараа нь Шүүх шинжилгээний газар. Тэгээд шийдвэр гүйцэтгэх газар.

Б.Жавхлан: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Тодорхой нэг төсөл асуулаа. Сүхбаатар аймаг дээр тэр байгууламжийн төсөл нь 2022 онд анх суугдсан. Сая төсөв хэлэлцэх үед шинээр суугдсан төсөл бол биш шүү. Тэгэхээр Хэмнэлтийн хэмнэлтийн хууль маань 22 онд батлагдсан хууль. Энэ төсөл 21 онд 22 оны төсвийг ярих үед тэр намар батлагдсан гэсэн үг. Ингээд 22 оноос хойш төсөл нь явж байгаа. Ирэх жил 25 онд дуусна. Ирэх жилийн үлдэгдэл санхүүжих дүнг сая төсвийн хэлэлцүүлгийн үеэр нэмэгдсэн. Ер нь өнгөрсөн сая төсвийн хэлэлцүүлгийн үеэр Улсын Их Хурал дээр гишүүдийн дийлэнхээр дэмжсэн төслүүд бол ихэнх нь ер нь буцаж орж ирсэн байгаа. Энд Сүхбаатар аймаг гэж дурдсан учраас Сүхбаатар аймаг дээр 2 төсөл, нэг нь санхүүжих дүн нь нэмэгдсэн, нэг нь шинээр тавигдсан. Шинээр тавигдсан дүн нь аймаг дахь аудитын барилгыг шинээр эхлүүлэх байсан. Тэр бол хасагдсан байгаа.

Д.Цогтбаатар: Жавхлан гишүүний микрофоныг гүйцээгээд өгье.

Б.Жавхлан: ХЭҮК-ын тэр барилга санал нь бол ирсэн. Тэгэхдээ нөгөө зураг, төсөв нь батлагдаагүй байсан учраас ороогүй. Энэ жил Эдийн засгийн хөгжлийн сайдын багц дээрээс зураг, төслийн мөнгө нь тавигдаад, санхүүжилт нь хийгдээд, зураг нь хийгдэж байгаа юм байна.

Д.Цогтбаатар: Шүүх шинжилгээний газар 9 дүгээр микрофон.

Ж.Буянбат: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Шүүх шинжилгээний ерөнхий газар сая өнгөрсөн төсөв дээр хөрөнгө оруулалтын зардал 4,3 тэрбум төгрөг батлагдсан байсан. Дахин өргөн мэдүүлсэн төсөл дээр 20 хувь хасагдаад 3,5 тэрбумын лабораторийн техник, тоног төхөөрөмжийн ийм хөрөнгө оруулалтын зардал тусгагдчихсан явж байгаа.

Д.Цогтбаатар: Жавхлан гишүүний микрофоныг өгье.

Б.Жавхлан: Ер нь энэ жил манай ХЗДХЯ-ны харьяа байдаг манай төрийн тусгай агентлагуудын ялангуяа хөрөнгө оруулалтын зардал чамгүй нэмэгдсэн байгаа шүү. Ийм ч шаардлага хэрэгцээ бол байгаа. Цаашдаа ч нэмэгдэх шинжтэй байгаа. Яг ковидын цаг хугацаа хүртэл, ковидын 2, 3 жилийн хугацаанд ерөөсөө яг энэ Батлан хамгаалах яам, Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх төрийн тусгай албад бол санхүүжилт урсгал зардалд ялангуяа нормативт зардлууд санхүүжилтүүд нэлээн хоцорсон. Энийг сүүлийн 2-оос 3 жил, 2 жилийн дотор нөхөх гээд үзэж байна. Цаашдаа ч бас энэ санхүүжилтүүд ингээд нэг явна.

Цагдаагийн байгууллага болон шүүхийн байгууллагуудаас энэ жил тавигдсан байсан тоног төхөөрөмж шүү, эд хогшил биш, тавилга, эд хогшил биш, тоног төхөөрөмжүүд яг бусад салбаруудын жишгээр ингээд хасагдсан. Тэгэхдээ

хасагдсан хэдий ч энэ жилийнхээ төсвийн санхүүжилтээс өндөр байгаа. Тэгэхээр энэ жилийнхээ хэмжээнд ямар ч байсан үйл ажиллагаа бол доголдохгүй.

Д.Цогтбаатар: ШШГЕГ хэддүгээр микрофон байна вэ, 9 дүгээр микрофон.

А.Намсаманд: ШШГЕГ-ын Тэргүүн дэд дарга, хурандаа Намсаманд. Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Хүүхдийн хорихын барилгын асуудал сүүлийн жилүүдэд нэлээн анхаарал татсан асуудлын нэг байсаар ирсэн манай байгууллагын. Хүний эрхийн байгууллагууд болон гадна, дотнын байгууллагуудын шүүмжлэл дагуулсан энэ орчин нөхцөл нь муу байна, энэ барилга байшин хуучирсан байна гэдэг асуудал яригдаад энэ жилийн төсөвт 1,8 тэрбум, нийтдээ бол 6,4 тэрбум төгрөгийн өртөг бүхий барилгын ажил энэ жил эхэлсэн. Тендер шалгаруулалтаар шалгарсан компани нь энэ жилийнхээ төсвийн хүрээнд хүүхдийн хорихын олон улсаас тавьдаг, хүний эрхийн байгууллагууд тавьдаг жишиг норматив, стандартад нийцсэн барилгын асуудлыг бол эхэлчихсэн явж байгаа. 25, 26 оны төсвүүд дээр үлдэгдэл төсвүүд бол 2, 3 он дамжин шийдвэрлэгдэхээр тусгагдсан байж байгаа.

Нөгөөтээгүүр Сайнзориг гишүүний түрүүн асуусан асуулттай холбогдуулаад тодотгоод хэлэхэд энэ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд хорих ангийн харуул хамгаалалтыг.../минут дуусав/

Д.Цогтбаатар: 9 дүгээр микрофоныг гүйцээгээд өгье.

А.Намсаманд: Хорих ангийн харуул хамгаалалт, хорих ангийн харуул хамгаалалтыг 4 ээлжээр зохион байгуулна гэсэн хуультай. Нөгөөтээгүүр ХЗДХ-ийн сайд болон Сангийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын хамтарсан жишиг нормативаар 20 хоригдол тутам нэг харуул хамгаалалтын ажилтан гэсэн жишиг норматив байдаг хэдий ч өнөөдрийн бодит байдал дээр 150-аас 170 хоригдлыг 1 харуул хамгаалалтын ажилтан харуул хамгаалалт биечлэн хяналтыг тавьж байгаа нь өөрөө маш өндөр эрсдэлтэй. Нөгөө хоригдлууд түрүүн ярьдаг орговол яах вэ, дайруул довтолбол яах вэ гэдэг асуудал.

Дараагийн дугаарт энэ Шүүх байгуулах тухай хууль энэ оны 5 сарын 22-ны шинэчилсэн найруулгаар манай байгууллага дээр хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн этгээдийг бид хүнгүйгээр авдаг болж байгаа, болох. Одоогийн байдлаар нөгөө төсөв хүн, орон тоо хүч, орон тоо шийдэгдээгүй учраас манай байгууллага хараахан хүлээж аваагүй байна. Хэрвээ манайх хүлээж авсан тохиолдолд өнөөдөр улсын хэмжээнд шүүхээс хорих биш, хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн мянга гаруй этгээд ялаа эдлээгүй байгаад эдлээгүй байгаад байгаа л даа. Энэ асуудлыг бид 21 аймаг, хот суурин болгонд эрэн сурвалжилна. Нөгөөтээгүүр ЭХХШТХ-ийн 2017 оны шинэчилсэн найруулга, өөрчлөлт.../минут дуусав/

Д.Цогтбаатар: 9-ийг гүйцээгээд өгчихье, хариулаад дуусгая. Энэ хүүхдийн асуудал чухал асуудал.

А.Намсаманд: Хязгаарлах тогтоох, таслан сэргийлэх арга хэмжээг манай байгууллага авч хэрэгжүүлэх болж байгаа. Тийм учраас энэ хязгаарлалт тогтоох арга хэмжээг манай байгууллага хэрэгжүүлсэн тохиолдолд мөн ялгаагүй хүн хүчний асуудал. 21 аймаг, хот суурин болгонд энэ арга хэмжээг таслан сэргийлэх

арга хэмжээг хэрэгжүүлнэ. Сүүлийн жилүүдийн дунджийг нь харахад бол 4-өөс 5 мянган хүнд энэ төрлийн таслан сэргийлэх арга хэмжээ авах, авсан ийм статистик тоо үзүүлэлт байгаад байгаа юм. Тийм учраас манай байгууллага энэ таслан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн тохиолдолд ялгаагүй жил тутам тэгээд л 4-өөс 5 мянган цахим гавын асуудал, тэгээд энэ үйл ажиллагааг хэрэгжүүлэх алба хаагчдын орон тоо, ажлын байр, байр, цалин, орон тооны асуудал мөн яригдах зайлшгүй шаардлагатай байгаад байгаа юм. Түрүүн сайдын хэлсэн үгэнд хэлж байсан. Орон тоо бол зөвхөн манайх нормативаараа авч үзвэл 1300 харуул хамгаалалтын ажилтны орон тоо дутуу байгаа. Саяын ярьсан тэр таслан сэргийлэх арга хэмжээ, хорихоос өөр төрлийн энэ тэр энэ орон тоог нэмбэл илүү өндөр тоо гарахаар. Зөвхөн энэ жилийн тухайд нэн шаардлагатай байгаа 447 орон тоогоо бид бүхэн санал оруулчихсан.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Баярлалаа. Би нэг асуултдаа яг Жавхлан сайд болон Алтангэрэл сайд 2-оос авмаар байна. НҮБ-ын цагдаагийн зөвлөх болон комиссарын өмнө нот бичиг байгуулж, амлалт авчхаад бид 170 хүнтэй цагдаагийн баг бүрэлдэхүүнийг энхийн сахиулах ажиллагаанд оролцоно, оролцуулна гэж авчхаад ингэж ухарч болж байгаа юм уу? Энэ өөрөө 7,4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт, тоног, төхөөрөмжийн зардал гаргачхаад, тэр жилдээ багаа илгээж чадах юм бол 16 тэрбум төгрөгийн орлого улсад орж ирнэ шүү дээ. Үүнээс нь хэдэн цагдаа ч гэсэн хэдэн байрны урьдчилгаатай болно, буцаад энэ улсын төсөвт ч гэсэн тодорхой хэмжээний орж ирнэ. Бид өөрсдөө ингэж болохгүй. За гэж аваад Гадаад хэргийн яам зөвшөөрөөд ингээд зурчихсан ийм нот бичгийн юмнууд дээрээсээ ингэж ухраад, тэгээд ийм инээдтэй. Дахин, дахин манайд ийм энхийг сахиулах ажиллагаанд цагдаагийн баг яахад дараа нь итгэх юм уу бид нарт. Тэгээд зарим зүйлүүдийг бас нэг учиртай байхгүй бол ингээд хоморголоод байх юм бол, мэдээж энэ байгууллагад зөндөө бий. Тэгээд хүний эрх гэж ярьдаг хүмүүс байгаа.

Д.Цогтбаатар: Эрдэнэболд гишүүний микрофоныг өгье. Энэ чинь цагдаа, Хууль зүйн сайдаас. Хууль зүйн сайд эхлээд хариульъя. Тэгээд Сангийн сайд хариульъя.

О.Алтангэрэл: Энхийг сахиулах үйл ажиллагааг дэмжих тухай хуулиар манай цагдаагийн байгууллага энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцохоор болсон. Энэ бол цагдаагийн албан хаагч олон улсын жишигт хүрч хууль сахиулах энэ дадлаа олж авах, дээрээс нь олон улсын тавцанд Монгол Улсынхаа нэр хүндийг өндөрт өргөх, энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцох, бас үүнээс дутахгүй нэг асуудал бол цагдаагийн байгууллагын албан хаагчдын хувь хүн талаас нь, албан хаагч талаас нь нийгмийн асуудал нь шийдвэрлэгдэнэ. Энэ энхийг сахиулах ажиллагаанд гаргаж байгаа нийт хөрөнгө зардлыг цагдаагийн байгууллага бол цаад тал нь 1,8 жилийн дотор буцаад улсын төсөвт төвлөрүүлнэ гэсэн ийм тооцоотойгоор энэ удаагийн төсөвт цагдаагийн байгууллага саналаа өгсөн.

Д.Цогтбаатар: Жавхлан сайдын микрофоныг өгье. Ямар ч гэсэн Хууль зүйн сайд бол саналаа өгчихсөн байгаа юм байна. Жавхлан сайд ямар хариу барьж байгаа вэ?

Б.Жавхлан: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Өмнөх бид хэлэлцүүлгээр чинь төсөв хасна, танана гээд тийшээгээ хошуурцгаасан. Одоо хасахгүй танахгүй, нэмнэ гэдэг чиглэл рүүгээ л бүгдээрээ хошуурцгаагаад явж байна л даа. Энэ дунд л тэгээд байгаа орлогын орлогынхоо хэмжээнд төсөв өргөн баригдана шүү дээ. Тэгэхээр би аль нэг үйл ажиллагаа, аль нэг төсөл хөтөлбөрүүдийг онцолж заамааргүй байна. Ер нь хөрөнгө оруулалтуудын хувьд бүгд жигд ялангуяа тоног, төхөөрөмж дээр шүү 20 хувь хасагдсан байгаа. Энэ дотор ч гэсэн энэ цагдаагийн байгууллага дээр тавьсан энхийг сахиулах үйл ажиллагаанд зориулагдсан 36 тэрбум байх. Тэгээд 36 тэрбум төгрөг нийтдээ байсан, тэрнээс 20 хувь бол хасагдсан байгаа. Жигд 20 хувь. Өмнөх жилүүд дээр бол цагдаагийн байгууллага дээр ийм тоног, төхөөрөмж бол бараг байгаагүй. Энэ жил огцом нэмэгдэж орж ирж байгаа нь сая Алтангэрэл сайдын хэлсэнчлэн энд хамрагдахаар болж байгаа, гадна талдаа бид энэ оролцох.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Жавхлан сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Тийм учраас энэ тоног, төхөөрөмж юмнууд бүрэн хасагдаад, оролцож чадахгүй хэмжээнд оччихсон гэж хэлж тэгж бодохгүй байна. Бид тодорхой хэмжээнд оролцоод тоног, төхөөрөмж юмнууд нь бол хангагдаад явна.

Өөр манай шүүхийн шийдвэрийнхэн байна уу? Шүүхийн шийдвэрийнхэн бол энэ жил тоног, төхөөрөмж нь дажгүй нэмэгдсэн, сайн ч нэмэгдсэн байгаа. Ирэх жилүүдэд ер нь СОР гээд манайд их олон улсын томхон НҮБ-ын хэмжээний ийм форумууд болно. Тийм учраас тусгай албадыг ер нь нэлээн тоног, төхөөрөмж болон бусад шаардлагатай материалаар эртнээс хангалтыг нь сайжруулах ийм чиглэл ирсэн учраас энэ дагуу явж байгаа.

Д.Цогтбаатар: Эрдэнэболд гишүүний микрофоныг өгье.

С.Эрдэнэболд: Сая бүлгийн хурал, тэгээд дараа нь чуулган дээр бид яг энэ асуудлыг ярихад маш хурдтайгаар асуудал явагдсан учраас би детальчилж танилцаагүй байсан тухайн үед. Жавхлан сайдаа тэгээд яасан гэхээрээ Тэргүүн Шадар сайд бол бид нарт тэвчиж болох зардлуудыг хасаж байгаа гэдэг ойлголт өгч байсан. Энд бол тавилгуудын зардлыг хасаж байна, гадаад томилолтын зардлыг 50 хувь хасаж байна эд нар гэдэг ийм зарчмын юм хэлсэн байхгүй юу. Тэгээд ер нь одоо бид нарын зовлон юу байна гэхээрээ төсөв данхайчихлаа тана, тана гээд байдаг. Танангуут нь болохоороо танах ёсгүй юм таначихлаа гэж асуудал гараад байгаа. Энэ хаана, ямар алдаа байна гэхээрээ нөгөө өмнөх удаагийн хэд хэд хэдэн хурал дээр хэлээд байгаа бид чинь аудит нь ажлаа хийх гэсэн чинь төсвөө Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцэж байгаа эсэхийг хянаад, нөгөө эрэмбийн асуудлаа гаргаж байгаад төсөв зохиох болон тэр хасалт таналт явагдах ёстой байсан. Энэ хийгдээгүйгээс болоод л ийм болоод байгаа юм. Тийм учраас лоббитой газруудынх нь яваад байгаа юм шиг ойлголт төрчихсөн байна.

Сангийн сайдаас нэг асуулт байгаа нь сая Цэнгүүн гишүүн нэг мэдээлэл хийж байна. Эрчим хүчний реформын үндэсний хороонд энэ эрчим хүчний реформыг олон нийтэд сурталчлах зорилгоор 8 тэрбум төгрөгийг төсөвт оруулсан байна гэсэн мэдээллийг хийж байгаа. Энэ үнэн, худлаа эсэхийг би мэдэхгүй байна л даа. Хэрвээ үнэн бол энэ чинь тэгээд олон нийтэд яг энийг ойлгуулах хүрээнд хэвлэл мэдээлэлд 8 тэрбум төгрөг гэдэг бол асар их зардал тийм биз. Тэгэхээр ач

холбогдлынхоо эрэмбийг бид тодорхойлно. Хэрвээ худлаа асуудалгүй шүү, харин үнэн бол энэ дээр та хариулаад өгөөрэй.

Дараа нь болохоор бид сая ХЗБХ-ныхон, Улсын Их Хурлын дарга эд нар баахан хууль хүчний байгууллагаар явсан. Тагнуул, АТГ, хорих ангиуд эд нар гээд явсан. Маш олон зовлонгууд байсан, ШШГЕГ зовлон байсан, ХЭҮК дээр зовлон байсан, ШЕЗ дээр баахан зовлон байсан. Энэ дотроос энэ Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн төсвийг 1 тэрбумаар буюу ойролцоогоор 10 хувиар хассан юм байна. Эртээд чуулган дээр бол Тэргүүн Шадар сайд юу гэсэн гэхээрээ боловсролын байгууллага болон эмнэлгийн байгууллага, энэ эрүүл мэндийн салбар болон боловсролын байгууллагаас таналт хасалт хийхгүй гэж байсан. Тэгээд нэг талаасаа энэ нөгөө шударга ёсыг хангах, хүний эрхийг хамгаалах чиглэлийн институтүүдийнх нь үйл ажиллагаа төсвийн таналтаас болоод доголдох хэмжээнд хүрчихсэн.

Нөгөө талаас нь болох юм бол энэ эрүүл мэндийн асуудал чинь манайх Монгол хүний өрсөлдөх чадвар, хүний нөөцийн энэ нөхцөл байдал хэр байгаа билээ? Энэ дээрээ бид ингээд хасалт хийх нь зөв юм уу? Ер нь энэ эмнэлгийн салбар, тэр тусмаа эрүүл мэндийн салбар дээрээ ингэж танах нь зөв юм уу? Би судалгааг нь харсан чинь 21 онд тус эмнэлгээр 170, 22 онд 180, 23 онд 200 мянган хүн үйлчлүүлсэн. Тэрбум төгрөг хасчихаар чинь дахиад энд нь доголдол үүснэ. Тэрийг нь хасахдаа ядаж энэ priority буюу энэ эрэмбээ барихдаа энэ эмнэлэг, сургууль, боловсролын газар дээрээ арай өөр нөхцөлтэй хандаж болох уу?

Дээрээс нь тэвчиж болох зардлууд дээр ер нь нийтдээ энэ танаж байгаа нийт зардлын хэчнээн процент нь яг энэ тэвчиж болох болох зардлын хасалтууд явж байгаа юм бэ гэдгийг хариулж өгөөч. Тэгээд түрүүний тэр 8 тэрбум төгрөг дээр.../минут дуусав/

Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин 15 цаг 11 минутаас хуралдааныг даргалав.

Х.Тэмүүжин: Сангийн сайдын микрофон.

Б.Жавхлан: Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя. Эрчим хүчний шинэчлэлийн хорооноос энэ чинь 8 ч биш, 13 тэрбум байх, 13 тэрбум төгрөгийн санхүүжилтийн төсөв ЗГ дээр хүсэлт тавьсан. ЗГ дээр яригдаад энэ саяын таны хэлсэнчлэн тэр 8 тэрбум орчим нь 8 тэрбум байх, 8 тэрбум орчим дүн бол тавигдсан байгаа шүү. Тэгээд Эрчим хүчний хороон дээрээс энэ хүсэлт нь ирээд, ЗГ дээр яригдаад, дүн нь хасагдаад, 8 тэрбум төгрөгөөр тавигдсан байгаа. Задаргаа нь юу, юу байсан тэр талаар манайхнаас задлаад мэдээлэл өгөөдхөөрэй нэгд.

2 дугаарт хар даа, энэ жилийн жишээ нь 35 их наяд төгрөгийн төсвийн 26 их наяд нь урсгал зардал юм байгаа юм. Тэгээд та түрүүн эрэмбэлсэнгүй гэж байгаа юм. Түүнтэй санал нийлмээргүй байна. Эрэмбэлээд огт хүрч болохгүй урсгал зардал нь үндсэндээ бараг 16 их наяд болж байгаа. Хүүхдийн мөнгө, ЭМД-ын сан, Нийгмийн даатгалын сан, гадна талдаа олон улсын гэрээтэй зээл, тусламжийн хүү, үндсэн төлбөр гээд. Ингээд нөгөө тэтгэвэр юуны, төрийн албан хаагчдын цалин нэмэгдэл гээд нийтдээ 16 их наяд дээр бид хүрч болохгүй, хүрч чадахгүй. Бүгд өөрөө цаанаа хуулийн зохицуулалттай, хуулийн заалттай. Тэгэхээр эрүүл, энэ

дотор жишээ нь 26-аас чинь 16 нь ингээд хасчихаар цаана нь хэмнэлт хийж болох, танаж болохоор зардал нь ингээд нийт 26-гийн чинь 10 нь гэхээр хэд нь болж таарч байна 1/3-ээс илүү 40-өөд хувьд нь бид хүрч хэмнэлт хийж болохоор хэсэг нь үлдэж байгаа байхгүй юу.

Тэрний чинь 4 их наяд нь зөвхөн эрүүл мэндийн салбарын, нийгмийн даатгалын, би худлаа ярих гэж байна шүү. Боловсролын салбарын 4 их наяд байгаа. Харин ЭМД-ын сангаас санхүүждэг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ бол огт хасагдаагүй. Огт хасагдаагүй. Эрүүл мэндийн салбарын хасагдсан дүн нь үйл ажиллагаатай холбоотой, яамны үйл ажиллагаатай, агентлагуудын үйл ажиллагаатай холбоотой аж ахуйн урсгал зардлууд хасагдсан. Тэрнээс биш ЭМД-ын сан бол харин ч нэмэгдсэн байгаа. 360 тэрбум төгрөгөөр нэмэгдээд, энэ жил бүр 2,3 их наяд хүрсэн. Ковидын үед 1,3 их наяд байсан. Тийм учраас жил болгон ЭМД-ын сангийн үйл ажиллагаа тэлээд, тэлсэн хэмжээгээр төсвөөс татаас очдог болж байгаа. Ер нь 60 хувь нь төсвийн татаасаар, 40 хувь нь ЭМД-ын шимтгэлээр дөнгөж санхүүжээд өөрөө ийм алдагдалтай явдаг ийм төсөв юм байгаа юм.

Тийм учраас зардал нэмэхээс илүү, хасах өөрөө маш хэцүү байдаг. Энэндээ тохируулаад төсөл хөтөлбөрүүд, төлөвлөгөө зорилтуудаа тавьчихсан байдаг. Эргээд ЗГ-ын салбар салбарын үйл ажиллагаанууд дээр доголдол үүсэх ийм эрсдэл байгаа. Тэрийг бол ойлгож байна. Гэхдээ нэгэнт ийм шийдвэр гарчихсан, төсвөө бид алдагдалгүй төлөвлөх шаардлагатай болж ирж байгаа учраас манай яамнууд энийг бол маш сайн ойлгоод, ямар ч байсан байгаа дахин төлөвлөсөн төсөвтөө үйл ажиллагаагаа багтаагаад явъя л гэцгээж байгаа. Тийм.

Х.Тэмүүжин: Саяын 2 асуулттай холбоотойгоор нөгөө эрхлэх асуудлын хүрээнд ХЗДХ-ийн сайдын эрхлэх асуудал дотор эмнэлэг, сургууль 2 байгаа. Тэгээд эмнэлэг, сургууль 2-ыг төлөөлж ирсэн хүн байгаа юм уу? 9 дүгээр микрофон.

Н.Одонгуа: ХЗБХ-ны дарга болон гишүүд та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн захирал, анагаах ухааны доктор, дэд профессор Одонгуа байна. Сая бол Жавхлан сайдын хэлж байгаа тайлбар дээр нэмээд би нэг товчхон тайлбар хүргэе. ЭМД-ын сангаас санхүүжүүлж байгаа манай тус эмнэлэгт олгох санхүүжилтийн 6,2 тэрбумыг хассан байгаа. Энийг бол бид гэрээлэлтийнхээ хүрээнд шаардлагагүй хэвтэлтүүд болон бүхий л зүйлийг маш бодитой төлөвлөж энэ дээр нэлээн ажиллаж хассан. Та бол маш сайн мэдэж байгаа. Энэ тусгай нэгдсэн эмнэлэг маань төрийн Хууль зүйн яамны харьяа, харьяа байгууллагуудаас гадна Чингэлтэй дүүргийн иргэдийн ачааллыг хуваалцдаг. Энэ хүрээнд ЧД-т нэг ч MRI, СТ байдаггүй. Тэгэхээр энэ ажлуудыг манайх тусламж, үйлчилгээг хүргэх.../минут дуусав/

Х.Тэмүүжин: 1 минут нэмж өгье.

Н.Одонгуа: Эдгээр тусламж, үйлчилгээг хүргэх зорилгоор өндөр өртөгтэй тоног, төхөөрөмжийнхөө урсгал засварыг хийх шаардлага гарсан. Эмнэлэг байгуулагдсанаас хойш 8 жилийн хугацаанд барилга байгууламж болон өндөр өртөгтэй тоног, төхөөрөмжийн урсгал засварыг хийгээгүй байгаа гэдгийг танд энэ ташрамд хэлмээр байна.

Х.Тэмүүжин: Дотоод хэргийн их сургуулиас хүн байна уу? Байхгүй юу. Хэн бэ? Микрофон тэр 9 дээр яваад оччих. 9 дүгээр микрофон.

Д.Эрдэнэбаатар: Дотоод хэргийн их сургуулийн Тэргүүн дэд захирал Эрдэнэбаатар. Дотоод хэргийн их сургуулийн тухайд саяын яригдсан энэ шатахууны зардал болоод энэ бусад зардалтай холбоотой юман дээр бол тайлбар байхгүй. Сургуулийн тухайд ЦЕГ, ХХЕГ, ШШГЕГ, ОБЕГ, ШШЕГ, дотоодын цэрэг гэсэн үндсэн 6 байгууллагын захиалгаар алба хаагчдыг бэлтгэж байгаа. Үүнтэй холбоотойгоор сүүлийн 5 жилийн судалгаанаас үзэхэд энэ агентлаг байгууллагуудын орон тоо нэмэгдсэн, хүний эрхийг хангах, хүний эрхийг дээдлэхтэй холбоотой сургалтын агуулгыг нэмэгдүүлэх шаардлага тавьж байгаатай холбоотойгоор зарим орон тоонуудыг нэмэгдүүлэх саналыг жил болгон өгч байгаа. Энэ жилийн төсөвт мөн тодорхой зарим орон тоонуудыг.../минут дуусав/

Х.Тэмүүжин: Нэмэлт 1 минут өгье.

Д.Эрдэнэбаатар: Дараачийнх нь нэг асуудал нь өнгөрсөн жил батлагдсан Боловсролын багц хуультай холбоотойгоор Дотоод хэргийн их сургууль дээр бэлтгэдэг ахлагч бүрэлдэхүүнийг бэлтгэдэг сургуулийг мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв байсныг ЗГ-ын тогтоолоор сургууль болгож өргөтгөн зохион байгуулсантай холбоотой зарим орон тоонууд нэмэгдэхээр санал өгсөн байгаа. Танилцуулж дууслаа.

Х.Тэмүүжин: Тэр 8 тэрбумын задаргааг хэлэх хүн байгаа юм уу? Уг нь манай Байнгын хорооны эрхлэх асуудал биш байна л даа. Тэр нарийвчилж тэр задаргаа хэлэх хүн байгаа юм уу ер нь? Хэн юм бэ? Байхгүй байна. Юун дээрээс нь эрчим хүч хариуцсан Байнгын хороо дээрээс хүнийг нь хүнтэй нь холбогдуулаад асуучих уу Энхболд гишүүнээ. Дараагийн Баасанжаргал гишүүн.

Х.Баасанжаргал: Би 3, 4 асуулт байна.

Х.Тэмүүжин: Баасанжаргал гишүүний юу явж байна. Та асууя.

Х.Баасанжаргал: Дахиад эхнээс нь цагийг. Энэ Номинчимэгийн асуултыг бас давхар асуух юм. Тэгэхээр нөгөө цаг гээд байгаа юм. 1 дүгээрт энэ нөгөө ЦЕГ болоод, АТГ, ялангуяа АТГ бол орон нутагт нэгжгүй. Тэгэхээр энэ байгууллагын томилолтыг, цагдаагийн байгууллагын томилолт, бичиг хэргийн зардлыг хасаж байгаа нь хэр оновчтой вэ? Түрүүн манай зарим гишүүд дурдсан. Тэртээ тэргүй хүрдэггүй зардал, тэгээд дахиад хасаад ороод ирэх нь дахиад энэ үйл ажиллагаа нь доголдох вий гэдэг нэг ийм зүйл байна.

2 дугаарт энэ хөдөлмөр хамгааллын зардлыг би хасаад байгааг ерөөсөө ойлгохгүй байх юм. Энэ хуулиараа норм, дүрэм журамтай зардал биш байдаг юм уу? Энийг яг ингээд нийтээр нь 10 хувиар хөдөлмөр хамгааллын зардал хасагдах гээд байгааг тайлбарлаад хэлээд өгөөч гээд.

3 дугаарт ХЭҮК-ын зардал дээр 678 сая төгрөг юм уу, 678 гэж төгрөг хасагдсан байна. Тэгээд энэ яг ямар зардал хөрөнгө оруулалтын зардал гэж байх шиг байна. Тэгэхдээ энэ нөгөө зураг төсвийн мөнгөнөөс нь хасагдаад байна уу, энэ ямар зардал вэ гэдгийг тодруулъя.

Тэгээд хамгийн сүүлд энэ нөгөө бид түрүүчийн яг анхны төсөв хэлэлцэх үеэр энэ Шүүхийн тухай хуулийн 46.8 дахь заалт хэрэгжихгүй юм уу гээд л манай Байнгын хороо хэлэлцэж байгаад л энэ өмнөх энэ Байнгын хороо ШЕЗ-ийн өргөн барьсан төслийг Байнгын хороогоор хэлэлцэж баталгаажуулсан төсвийг бууруулахгүй гэдэг зарчим бариад бид нэлээн юм болж байж нэмсэн. Тэгээд яг энэ Шүүхийн тухай хуулийн энэ 46.8 дахь заалт энэ удаагийн төсөв хэлэлцэхэд үйлчлэхгүй юу гэдгийг тодруулж асууя.

Номинчимэг 3 асуулт асуусан. ШЕЗ, Шүүхийн сахилгын хороо төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагааны улмаас хохирол төлөх гээд энэ 3 дээр нэмэгдэж орж ирсэн байна гээд төсөв нэмэгдэж орж ирсэн гээд. Энэ 3-ыг тайлбарлаж өгөөч гээд Номинчимэгийн асуултыг давхар асуучихъя.

Х.Тэмүүжин: Сангийн сайд Жавхлан.

Б.Жавхлан: Зардлаа хасна, хасна гээд байсан, одоо бүгдээрээ л яг хасахгүй, хасахгүй л болоод явчихлаа. Хэрвээ хасахгүй ийм шалтгаан, ийм зардлууд байдаг бол өмнөх хэлэлцүүлгийн үед хэлж байх хэрэгтэй. Огт ярилцаагүй шүү дээ энэ талаар. Хасаж болохгүй гэж. Одоо тэгээд яг хасаад ороод ирэхээр бүгдээрээ хасахгүй, хасахгүй гэх юм. Хэрвээ ингэх юм бол энэ дээр хасах зардал ер нь нэг ч байхгүй. Бүх салбарууд дээр яг адилхан. Бичиг хэргийн зардал бид ямар ч байсан ковидын үед цахим орчинд ажиллаад л болоод л байсан. Тэрнээс хойш нэлээн нэмэгдсэн байгаа. Тэрэнтэй их харьцуулж сая ярьсан шүү дээ. Гадаад томилолтын зардал бид юун гадаад томилолт манатай хилээ хаалгачихсан байх үеийн гадаад томилолтын зардал гэж бараг тэг байсан. Тэгээд түүнтэй харьцуулж яриад бүүр хэдэн 100 дахин нэмэгдчихсэн байна гэж байгаад бүгдээрээ хассан. Бичиг хэргийн зардал дээр ч гэсэн яг ижилхэн. Тодорхой хэмжээнд бол ингээд хасагдаж байгаа.

Хөдөлмөр аюулгүй байдлын зардал энэ 0,5 хувийг төсвийг төлөвлөхдөө улсын төсөв дээр суулгана гэсэн ийм заалт байдаггүй. Төсвийн ерөнхийлөн захирагч тухайн төсвийнхөө жил төсвөө зарцуулахдаа өөрийнхөө төсөв дээрээс энийг гаргаж зориулна гэсэн байдаг юм 0,5 хувь хүртэл. Түүнээс биш төсөв дээр шууд энийг төлөвлөх тийм хуулийн үүрэг байхгүй гэсэн үг.

ШЕЗ юу гэлээ, ШЕЗ дээр бид саналыг ХЗБХ-ноос ирсэн тэр хэмжээгээр нь сууриар нь авсан. Тэнд бол огт хөдлөөгүй. Тоног, төхөөрөмж дээр нь бол бусад бүх салбаруудтай ижилхэн 20 хувиар танагдсан байгаа. Тэгэхээр бидний ойлгож байгаагаар цалин, тэр шинэ байшингуудынх нь санхүүжилт үүнийгээ бушуухан барьж дуусгах нь хамгийн чухал юм байна гэж ингэж ойлгож байгаа. Тэгээд 1, 2 жил төсөл үргэлжлэх байх тэр барилгуудын төсөл. Тэгээд ашиглалтад орохоор нэг мөр тоног, төхөөрөмжүүдээ тухайн үедээ 100 хувь хангагдаад явах байх. Энэ удаа яг тоног, төхөөрөмж бусад бүх салбаруудтай ижилхэн 20 хувь танагдаж байгаа учраас энэ дээр бол энийг бол тэвчээд үйл ажиллагаа нь нэг их айхтар тасалдахгүй болов уу гэж бодож байна. Тийм учраас нэг ингээд хасаад яваад үзье гэж байна.

Тэр нөгөө төрийн албан хаагч нарын буруутай үйл ажиллагаанаас нөхөн төлбөр. Ер нь энийг бид ойрын жилүүдэд нэг мөр нэг шийдээд дуусгачихмаар юм шиг байгаа юм. Алтангэрэл сайд энэ дээр нэлээн анхаарал тавьж байгаа. Тэр

буруутай төрийн албан хаагч нараас нь буцаагаад эргүүлэн төлүүлэх ажиллагаа нь хэдэн хувь, яаж байдаг юм байгаа юм. Сая эргэн төлөгдөх буцаад, буцаад төсөв өргөн барих үед Хууль зүйн яамнаас ирсэн билүү юунаас Эдийн засгийн хөгжлийн яамнаас, Эдийн засгийн хөгжлийн яамнаас ирсэн билүү, аль, алинаас нь хэд хэдэн буруутай үйл ажиллагаанаас гарах зардлуудыг нэмж тусгахаар санал ирүүлсний дагуу тодорхой хэмжээнд нэмж тусгагдсан байгаа. Өөр дутуу юм байна уу?

Х.Тэмүүжин: Шүүхийн сахилгын хороо, 2 байгууллага дээр нэмэгдсэн нэмэгдэж орж ирж байна гэсэн. Сахилгын хороо байгаа юу? Тийшээ 9 дүгээр микрофон руу очоод суучих уу.

Д.Мөнхзориг: Сайн байцгаана уу, та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Шүүхийн сахилгын хорооны Ажлын албаны дарга Мөнхзориг байна. Төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй зардал энэ 25 оны төсөв дээр нэмэгдэж ороогүйдээ уг нь? Хаана нь тийм байгаа юм бол?

Х.Тэмүүжин: Танай дээр нэмэгдэж байгаа зардал чинь уу?

Д.Мөнхзориг: Тийм.

Х.Тэмүүжин: Өөр, нэмэлт Номинчимэг гишүүний асуулт байсан. Номинчимэг гишүүн нэмээд тодруулаад асуучих.

О.Номинчимэг: Бүгдэд нь энэ өдрийн мэндийг хүргэе. Өнөөдөр олон улсын авлигатай тэмцэх өдөр. Олон улсын авлигатай тэмцэх конвенц батлагдсан өдөр болохоор ХЗБХ-ныхоо гишүүд болон ажлын алба, өнөөдөр энэ Байнгын хороонд төсвөө танилцуулж байгаа та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Шүүхийн сахилгын хороон дээр урсгал зардал 40 тэрбумаар нэмэгдээд ороод ирчихсэн байгаа юм. 25 онд 9 сард өргөн мэдүүлээд, батлагдсан хувилбараасаа нэмэгдээд цалин хөлсний нэмэгдэл урамшуулал 40,9 тэрбумаар нэмэгдчихсэн байгаа байхгүй юу. Энэ ямар учиртай юм бол? Анх өргөн мэдүүлснээсээ илүү нэмэгдээд орж ирэхээр гээд энийг тодруулж байгаа юм.

Х.Тэмүүжин: 9 дүгээр микрофон.

Д.Мөнхзориг: Сахилгын хорооны нийт төсөв 6,4 тэрбум гэж байгаа юм. Тэгэхээр 40 тэрбум гэхээр жоохон алдаатай мэдээлэл байгаад байх шиг байна. Байгууллага нь андуурагдчихсан юм болов уу.

Х.Тэмүүжин: ЦЕГ, АТГ-ын томилолтын зардлуудыг хасаж байгаатай холбоотойгоор тайлбар хийх үү? 2 дугаар микрофон. ЦЕГ, АТГ 9 дүгээр микрофон дээр очоод суучих.

Т.Сүхболд: ЦЕГ-ын дарга Сүхболд. Манайх томилолтын зардал бол яг 35-аас 40 хувьд өгч чаддаг. Ковидын өмнө байсан төсөвтөө ч ирэх жил хүрээгүй. Дээрээс нь Сангийн сайдын тушаалаар томилолтын зардал нэмэгдсэн байгаа. Энэ яах вэ тэгээд л нөгөө унааны мөнгө нэмэгдэж байгаа, буудлуудын мөнгө нэмэгдэж байгаатай холбогдоод нэмэгдэж байгаа. Тэгээд бид бол томилолтын зардлыг дандаа дутуу өгч явсан. Тэгээд одоо нэг ямар ч байсан бид 70 хувьд аваачья гэдэг төсвийн санал өгсөн юм.

Томилолтын зардлаас хэцүү бид 50 хувь хасагдаад байгаа зардал бол энэ бичиг хэргийн зардал байгаа. Цагдаагийн байгууллага 2024 оны хагас жил хүртэл хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, зөрчлийн хэрэг бүртгэгч, албан тушаалтнууд сард нэг бичгийн.../минут дуусав/

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар 15 цаг 28 минутаас хуралдааныг даргалав.

Д.Цогтбаатар: 2 дугаар микрофон нэмж хариулах уу? Гүйцээгээд хариулчих.

Т.Сүхболд: Хувийн зардлаараа нэг сард 1 боодол бичгийн цаас авдаг байсан. Энийг бол болиулсан. Энэ Хууль зүйн дотоод яамны сайдтайгаа ч ярьсан, Энхбаяр сайд ч гэсэн мэдэж байгаа. Энийг болиулъя гээд. Энхбаяр сайд байхдаа энэ тоног, төхөөрөмж буюу компьютер, принтер хувиас хэрэглэж байгааг бүгдийг нь болиулсан. Алтангэрэл сайд энийг болиулъя, нэг ч бичгийн цаас алба хаагч гаргахгүй гэдгийг яриад, тушаал гаргаад бүх бичгийн цаасыг нь энэ мөнгийг нь, мөнгөө, бичиг хэргийн зардлаа дуустал өгч байгаа. Бид тэгээд яамтайгаа ярьж байгаад, Сангийн яамтай ярьж байгаад хэмнэгдсэн төсвөөсөө бичгийн цаас тавиад он дуусгаж байгаа. Тэгээд бичгийн цаас маань бид нарт илүү ач холбогдолтой байгаа. Энэ бичиг хэргийн зардал.

Д.Цогтбаатар: АТГ 9 дүгээр микрофон.

З.Баасанням: Гишүүний асуултад хариулъя. АТГ-ын Тамгын хэлтсийн дарга Баасанням. Энэ өргөн мэдүүлж байгаа төсөв төсөл дээр, төсвийн төсөл дээрээс үндсэндээ байгууллагын төсвөөс 1,3 тэрбум төсөв хасагдсан байгаа. Үүний урсгал зардал дээрээс 935,7 сая төгрөг, үүн дотор гадаад, дотоод томилолтын зардал 50 хувиар буурсан байгаа. Энэ нь өөрөө үйл ажиллагаа хэвийн ирэх онд явуулахад жоохон учир дутагдалтай байж болзошгүй нөхцөл байдал харагдаж байгаа. Энэ томилолтын зардлын 50 хувь хасагдаж байгаа дээр.

Яагаад гэхээр авлигын гэмт хэргийн улмаас хулгайлагдсан хөрөнгийг буцаан авчрах чиглэл дээрээ нэлээн сүүлийн жилүүдэд ОУБ-тай хамтарч ажиллаж байгаа. Энэ хүрээндээ бид 13,9 сая ам.доллар буюу 47, 48 тэрбум төгрөгийн хохирлыг төсөвт буцаан төвлөрүүлсэн байж байгаа юм. Гадаадаас хулгайлагдсан хөрөнгийг буцаан авчрахад нэлээдгүй цаг хугацаа, зардал мөнгө ордог. Хэд хэдэн удаа.../минут дуусав/

Д.Цогтбаатар: 9 дүгээр микрофон гүйцээгээд хариулъя.

З.Баасанням: Уулзах уулзалт хийж байж энэ хулгайлагдсан хөрөнгийг буцаах юман дээр нэлээн үр дүнтэй ажил гардаг. Тэгэхээр энэ гадаад, дотоодын томилолтын зардал 50 хувь танагдсан дээр бол ирэх жилийн хувьд энэ чиглэлийн үйл ажиллагаа дээр хүндрэл учрах болзошгүй юм гэсэн ийм байдал харагдаж байна. 50 хувь хасалттай байгаа. Мөн орон нутагт нэгж байдаггүй, орон нутаг руу дандаа томилолтоор явж үйл ажиллагаа явж байгаа болохоор энэ дээр жоохон хүндрэл учрах магадлал байж болзошгүй гэж харж байна. Өөр зүйлгүй.

Д.Цогтбаатар: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий, Шүүхийн ерөнхий зөвлөл 4 дүгээр микрофон.

Л.Энхбилэг: ХЗБХ-ны дарга, гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. ШЕЗ-ийн дарга Энхбилэг. Номинчимэг гишүүний асуултад хариулъя. Бид 2021 оны Шүүхийн тухай хуулийг хэрэгжүүлээд явж байна. Энэ хууль хэрэгжсэнтэй холбогдуулаад шүүх, шүүхийн захиргааны албан хаагчдын цалин, тэтгэмжийн зөрөө гээд шүүхийн шийдвэртэй асуудлууд байгаад байгаа юм. Өөрөөр хэлбэл нөгөө цалин буурсан шүүгч шүүхэд хандсан. Мөн захиргааны албан хаагчид маань цалинтай холбоотой хуулийн хэрэгжилттэй холбогдуулаад шүүхэд хандсан энэ шүүхийн шийдвэр биелэгдээгүй, 24 оны төсөвт тусгагдаагүй. Тэгээд энийгээ бид 25 ондоо тусгаад явж байгаа юм.

Д.Цогтбаатар: Хариулт болсон уу? Хэнээс асуусан юм бэ, Жавхлан сайд. Жавхлан сайд хариулах уу. Тэгье, тэгье. Би энэ яг таны асуулт дээр надад бас асуулт байгаа байхгүй юу. Тэгээд энийг бид ярихгүй бол зайлшгүй яригдах асуудал наана чинь ингээд үлдчихэж байгаа юм. Би тэгээд дараа нь нэг базаад энэ дээр хэлчихье. Тийм, жич биш, би өөрөө тэртээ тэргүй асууж, энэ дээр ярих асуудал гарна. Сандаг-Очир гишүүн микрофоныг нь өгье.

Ц.Сандаг-Очир: Манай ХЗБХ-ны эрхлэх асуудлын хүрээний 10 гаруй байгууллага байдаг. Тэгээд эндээс нэг төсвийн өөрчлөлтөд хориг тавьсантай холбогдуулж 8 байгууллагын төсөвт өөрчлөлт орж байгаа юм шиг байна. Би аудитын дүгнэлтийг хараад байж байна. ХЗДХ-ийн сайд болоод бусад эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын төсөв нийтдээ сая өнгөрсөн батлагдаад хүчингүй болдог Төсвийн хуульд нийтдээ 2,3 их наяд, 2 их наяд 395 тэрбум байсан. Одоо ЗГ-ын өөрчилж оруулж ирснээр бол хоригтой холбоотойгоор 2 их наяд 367,4 тэрбум гэж орж ирж байна. Нийтдээ 27,6 тэрбумаар хасагдаж байгаа юм, буурч байгаа юм байна. Дотроо байгууллагуудын хувьд бол янз, янз байна, янз янз байна.

Тэгээд энд манай эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын дарга, орлогч дарга, нягтлангууд нэлээн гомдолтой сууж байгаа байх л даа. Сангийн яам нэг их айхтар саналыг нь сонсоогүй, тэгээд автоматаар хасаад явчхаж байгаа байх. Тэгээд энэ аудитын дүгнэлт дээр ч байна. Зарим урсгал зардлуудыг автоматаар хасаж байгаа нь, механикаар хасаж байгаа нь хэвийн үйл ажиллагаа алдагдах хэмжээнд байна. Жишээ нь бид ирэх жил цагдаагаас гэмт хэрэг зөрчлийг бууруул, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийл гэж ингэж шаардлага тавихад хэцүү болж байна шүү дээ. Томилолтын зардал, бичиг хэргийн зардлуудыг нь 50 хувь хасчихаар чинь дуудлагадаа яаж явах юм. Хэв журмыг яаж сахиулах юм. 365 хоногийн 200 гаруй хоногт нь Сүхбаатарын талбай дээр жагсаал цуглаантай байдаг болчихсон энэ нийгэмд гэдгээс харахад.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага байна. Мөн адилхан хоригдлуудын асуудал, ялтнуудын асуудал, хүний эрхийн асуудал. Шүүх, шүүхтэй холбоотой ШЕЗ, Сахилгын хороо, Дээд шүүхийн төсөв санхүүгийн асуудал байна. Тэгээд бид асуудал ярихаараа нэг их гоё баахан зовлон, жаргалыг нь сонсоод л яг төсөв орж ирэхээр нь тэгээд нөгөө нэг төсөв байхгүй зовлонгоор төсвийг нь хасчих юм. Тэгээд их зовлонтой. Тэгээд энэ дээр ингээд аудитын дүгнэлтээс харахад 5 байгууллагын нийтдээ 60,1 их наяд, юу тэрбум төгрөгийг хассан байна манай салбарын. Харин 3 байгууллагын 32,5 тэрбум төгрөгийг нэмсэн байна. Сая хүчингүй болсон Төсвийн

хуулиас сая одоо өргөн баригдаж байгаа хууль дээр. Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо, Улсын прокурор гэсэн энэ 3 байгууллага дээр 32,5 тэрбум төгрөгийг нэмсэн гэсэн байна. ХЗДХ-ийн сайдаас 57 тэрбум, Улсын дээд шүүхээс 1 тэрбум, АТГ-аас 1,3 тэрбум.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: Тэгээд ингээд 60,1-ийг хасаад, 32,5 тэрбумыг нэмээд, зөрүүд нь 27,6 тэрбумын хасалт хийгдэж байна л даа, хийгдэхээр орж ирж байна. Тэгээд Сангийн сайдыг энэ 27,6 тэрбум төгрөгийг заавал хасаад байх хэрэгцээ шаардлага байна уу, үгүй юү? Энэ хүчний байгууллага гэмт хэрэг зөрчилтэй холбоотой асуудлууд дээр ингээд дандаа шаардлага тавьж явдаг энэ байгууллагууд, хууль хэрэгжүүлж явдаг энэ байгууллагууд дээр 27,6 тэрбумынх нь төсвийг нэг зохицуулаад хасахгүйгээр оруулаад ирэх бололцоо боломжийг нэг гаргаж ирээч. Хэрвээ яахгүй гэвэл манай Байнгын хороо энэ чинь ЗГ-ын оруулж ирсэн төсөв. Бид Байнгын хороон дээрээ Улсын Их Хурал төсөв хэлэлцэж баталдаг учраас зарчмын зөрүүтэй санал гаргаж, ХЗБХ-н дээрээ эрхлэх асуудлын хүрээнийхээ байгууллагуудын төсвийг хамгаалж оруулах тал дээрээ та бүхнийг идэвхтэй ажиллаач гэж ингэж хүсэж байна. Шаардлагатай бол зарчмын зөрүүтэй санал гаргая.

Д.Цогтбаатар: Жавхлан сайд хариулах уу? Тэгье.

Б.Жавхлан: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Зарим нэг дүн жоохон зөрөөтэй дурдагдаж байна шүү. Хэрэв ингээд салбар салбараа ингэж ярих юм хэдүүлээ эргүүлээд л анхнаас нь л юмаа эхлүүлье. Энэ алдагдалтай төсөв гэж ярих уу, алдагдалгүй төсөв гэж ярих уу? Энэ зарчмаа уг нь аль, аль дээрээ ойлголцоод чиглэл өгсөн. Энэ чиглэлийн дагуу 2,4 их наядын энэ үйл ажиллагааны хойшлуулсан, хэмнэлт хийсэн, хэмнэлт юу байх вэ зардлаа танаж байна гэсэн үг л дээ. Ингээд арай гэж ЗГ-ын үйл ажиллагааг аль болох доголдуулахгүй тэгэхдээ ингээд нэг жигд зохицуулалт хийгээд оруулж ирсэн байгаа юм.

Тэгээд ажлын хэсэг байгуулагдаад, ажиллаад явж байгаа. Бид мөн хэлж байгаа. Одоо бид дахиад тэр салбараас, энэ салбараас хасаад, энэ салбарын юмыг ингэж нэмээд гэдэг тийм санал бид нэг төгрөгийн ч санал оруулах боломж байхгүй. ХЗБХ-ноос хуулийн дагуу яригдаад оруулж ирдэг төсвүүдийг бид маш хүндэтгэлтэй хандаж, бүгдийг нь оруулсан байгаа. Тийм учраас зарим салбаруудаас бүүр нэмэгдсэн харагдаж байгаа нийт дүнгээрээ. Тэгэхээр бусад асуудлыг бол бид санал хэлж мэдэхгүй байна. Тэгээд та бүхэн ярилцаад хэлэлцээд шийднэ биз.

Д.Цогтбаатар: Хариулт хангалттай юу? Да.Цогтбаатар гишүүн микрофоныг нь өгье.

Да.Цогтбаатар: Байнгын хорооны гишүүд болон ажлын хэсгийнхэнд энэ өдрийн мэнд хүргэе. 8 сарын 30-нд төсөв өргөн барьж байхад алдагдалгүй өргөн барих боломж бол байсан. Тэгээд яах вэ хазааргүй мэт явсан, 8 жил хэт олонх байсан нам. Засгийн газарт Ерөнхийлөгч алдагдалгүй төсөв батал, мөчлөг сөрсөн төсвийн бодлого хэрэгжүүл, урсгал зардлаа бууруул гээд хориг тавьж байж нэг юм алдагдалгүй төсөв өргөн баригдсан. Тэгээд түүн дээр нөгөө нисдэг бор морийг нь алаад ир гэсэн чинь нисдэггүй бор морийг нь алаад ирлээ гэдэг шиг энэ аудитын

дүгнэлт дээр тусгагдаж байгаа. Сая манай бусад гишүүд хэлж байна. Урсгал зардал болон энэ зураг төсөлгүй шаардлагагүй гэх юм уу тийм хөрөнгө оруулалтуудаа бол хасах боломж байсан. Тэгээд тэд нар нь дахиад энд орж ирж байгаа. Энд миний шүүж харснаар бол зураг төсөлгүй 18 төсөл, арга хэмжээ, их засвараас 7-г нь бол ... нь тэр чигтээ буцаагаад өргөн баригдсан байна.

Тэгээд энэ манай Байнгын хороонд харьяалагдаж байгаа энэ цагдаа, шүүхийн шийдвэр, дотоодын цэрэг гэдэг газруудын урсгал зардал зүгээр бүгдийг нь өндөр, намаар нь жагсааж байгаад пад гээд хасаад тавьчихаж байгаа юм. Яг энэ 8 сарын 30-нд өргөн барьсан төсвийг хэлэлцэж байх үеэр би хэлсэн. Сая энэ генерал Сүхболд дарга бас хэлж байна. Манай энэ томилолтын зардал угаасаа хүрдэггүй юм гээд. Би өмнө нь яг жишээтэй нь ярьж байсан юм. Баянхонгор аймгийн Эрдэнэцогт суманд цагдаагийн бензинийх нь мөнгө нэг суманд 100 мянган төгрөг очдог. Тэгээд тэр хүн чинь аймгийн төв рүү 2, 3 ирж, очоод дуусдаг, үлдсэн томилолтынхоо мөнгийг өөрийнхөө карманаас гаргадаг байсан байхгүй юу. Тэгээд энэ нь хүрэхгүй байна та нар энэ дээрээ анхаарч ажиллаарай гээд хэлж дуусаагүй байтал бараг ингээд араас нь дахиад томилолтынх нь зардлыг хасаад ороод ирж байгаа. Бичиг хэрэг сая бүгдээрээ л ярьж байна. Бүгдээрээ хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтаа хийдэг бичгийн цаас ч хүрдэггүй ийм нөхцөл байдалтай явдаг энэ цагдаа.

Тэгээд энэ шүүхийн шийдвэр чинь манайхан энэ хуулийнх нь нэр томьёо л тэр юм даа. Ялагдал, үгүй ээ юу гэлээ, яллагдагч, биш ээ хоригдол. Тэгээд уг нь хоригдож байгаа боловч тэнд чинь нэг хүний тухай асуудал яригдаж байгаа. Тэгээд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад бас л хүн ажиллаж байгаа. Хүн орон тоо нь хүрэхгүй явж ядаж байхад нь дахиад дээрээс нь орон тоог нь хасна, тэгээд дутуу байгаа орон тоогоо гүйцээгээд явчихъя гэхээр хасаад явуулчихдаг. Тэнд чинь бол дандаа ихэвчлэн л тулаа хийж байгаа, хүмүүс өвдөж болно, чөлөө авч болно. Тэр үед нь буцаагаад сая гарсан албан хаагч маргааш нь дахиад гараад явчхаж байгаа юм.

Сая энэ Улсын Их Хурлаас Стратеги, төлөвлөгөөгөө баталсан. Хүн төвтэй стратеги төлөвлөгөө гээд. Төрийн албан хаагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч ч тэр, цагдаа ч тэр Монгол Улсын төрийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулаад хүн тэнд ажил хийж байгаа. Тэгээд тэр хүндээ зориулсан төсвөө бид баталж чадахгүйгээр бүгдийг нь жагсааж тавьж байгаад бараг ингээд тэнцүүлээд хасаад хаячхаж байгаа дээр л жоохон асуудал үүсээд байгаа юм.

Тэгээд би Сангийн сайдаас асуух гээд байгаа юм нь ер нь хөрөнгө оруулалт, урсгал зардал дээр эрэмбэ гэдэг асуудалтай холбогдуулаад нэг хууль ч юм уу, журам боловсруулаад.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Гүйцээгээд хариулъя, микрофондоо асууя.

Да.Цогтбаатар: Энэ эрэмбэтэй холбоотой, хөрөнгө оруулалт болон урсгал зардалтай холбоотой асуудлуудыг хууль юм уу, журам боловсруулаад тэрнийхээ дагуу асуудлуудыг нь эрэмбэлж байгаад, тэрнийхээ дагуу хасдаг, нэмдэг байж болох уу л гэж асуух гэсэн юм.

Д.Цогтбаатар: Жавхлан сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Өнгөрсөн төсөв дээр хэлэлцэж байх үед зардал хасах, танах, хэмнэх талаар нэлээдгүй ярьж байсан гишүүдийн нэг гэж таныг би санаж байна. Буруу санаагүй бол. Ингээд алдагдалгүй төсөв бариад, өргөн барихаар байгууллагуудаа харж байгаад эсрэгээр нь ярина гэдэг хэр зохимжтой вэ? Байгууллагуудыг сугалж урсгал зардлыг хасах танах боломж бол ер нь байхгүй дээ. Маш хэцүү тэр бол. Онцолж илүү их хасах ч байдаг юм уу, танах, хэмнэх ёстой гэдэг салбар байхгүй.

Хөрөнгө оруулалтуудын хувьд одоо хөрөнгө, Төсвийн хөрөнгө оруулалтын тухай хуулийн төсөл яг эд хэлэлцэгдэж байгаа. 8 сард 25 оны төсөв өргөн барихад Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн санамж дотор энэ заалтууд орсон байгаа. Өмнө нь ч гэсэн бид энийг бол төлөвлөөд хийж явсан ажил. Удахгүй намрын чуулганд багтаад бид өргөн барихаар хичээж ажиллаж байна. Түүн дээр таны асуусан энэ асуултууд дээр эрэмбэ дарааллуудыг хэрхэн яаж тогтоох вэ, төсвийн хувьд шат шатны төсвийн хөрөнгө оруулалтуудыг аль шатдаа алийг нь хийх вэ, алийг нь хийхгүй байх талаар энэ тэр гээд нэлээн дэлгэрэнгүй орж ирнэ. Тэгсний үр дүнд цаашдаа төлөвлөх, мөн хэмнэх, хойшлуулах гээд иймэрхүү тохиолдлууд гарвал зохицуулалт хийхэд бол улам их амар хуульчлагдаад ингээд явна гэж ингэж бодож байна. Ер нь манай ХЗБХ-ны харьяа байгууллагуудын төсөв бол өмнөх жилүүдтэйгээ харьцуулахад өсөлтийн хувь хэмжээ бол бас их чамлахааргүй бол байгаа шүү. Тийм.

Цогтбаатар дарга асуусан, түрүүн Баасанжаргал гишүүн ч гэсэн асуулаа. ШЕЗ дээрээс оруулж ирж байгаа зардлууд эрэмбэ дарааллын хувьд бол хөрөнгө оруулалт шаардаж байгаа барилгын ажлууд нь ерөөсөө хамгийн нэгд тулчихсан ажил байгаа. Цалинтай холбоотой асуудлууд, тэр цалингийн нэмэгдэл энэ талаар шүүхийн бүүр шийдвэр гарчихсан. Шат шатны шүүхийн шийдвэр гарчихсан, Дээд шүүхийн шийдвэр гарчихсан. Энэ талаас ХЗБХ хий гэдэг, бид төлөвлөж орж ирэхдээ ингээд хасаад ороод ирдэг. Ингээд шүүхийн шийдвэр нь биелэгдэхгүй өнөөдрийг хүртэл явсан зүйл байгаа. 25 оных дээр бол бид төлөвлөөд оруулж ирсэн байгаа. Тийм учраас өсөлттэй харагдаж байгаа. Энэ 24 оных дээр ч гэсэн жоохон асуудал байгаа. Хэрвээ салбараас, төсвийн ерөнхийлөн захирагчаас нь жоохон хэмнэлт хэрвээ гаргах юм бол тэр төсвийн хуваарилалтаар тэр шүүхийн шийдвэрийг биелүүлэх боломж байна уу гэж бид харж байгаа. Ийм зохицуулалтууд л байгаа даа.

Д.Цогтбаатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Би нэг зүйлийг энд хэлнэ. Асуух гэхээр энэ их сонин зүйл болчихоод байгаа юм. Энэ Баасанжаргал гишүүний яг ярьж байгаа асуудал чухал асуудал байхгүй юу, тэгээд хариултгүй байгаа юм. Байнгын хорооны дарга би ямар өөрөөсөө асуулттай биш энэ чинь. Яагаад гэвэл системийн асуудал үүсчхэж байгаа байхгүй юу. Юу гэвэл тэр Шүүхийн тухай хуулийн 46 дугаар зүйл бол нээрээ энэ чинь зайлшгүй ингээд хэрэгжих ёстой хууль. Тэгтэл дахиад энэ чинь өмнө нь ерөөсөө байгаагүй прецеденттэй болохоор Төсвийн хуулийг бүхэлд нь хүчингүй болгоод буцаачихаар тэр хуулийг гаргах хүртэл тэр хуультай холбогдож явсан бүх процедур чинь буцчихсан байхгүй юу.

Тэгэнгүүт одоо шинэ бид дэгээ баталчихсан явж байдаг яг эндээ зориулсан. Тэгсэн энэ дотор тэр Шүүхийн тухай хуулийн, Шүүхийн 46 дугаар зүйл чинь ороогүй тусгагдаагүй явчхаж байгаа байхгүй юу. Тийм байгаа биз. Тэгээд энэ нөхцөл байдалтай холбогдуулаад энэ, одоо би гишүүд үг хэлэхээр нэмж, энэ дээр бол энэ

асуудал чинь гарчихсан үг. Ганцхан хариулт дараагийн ер нь энэ хоригийг хүлээж авах тохиолдолд төсвийг яаж хэлэлцэх вэ гэдэг тусгайлсан хууль гаргаж ирэхгүй бол нэг удаагийн хуулиар төсвийг хэлэлцээд яваад байж угаасаа болохгүй.

Ер нь 30 жил Монгол Улсын Ерөнхийлөгч хориг тавьчихаар бүхлээр нь хэзээ ч хүлээж авахгүй гэж бодож хууль ерөөсөө гаргаж болохгүй. Ихэнхдээ хүлээж авахгүй байж болно. Тэгэхдээ хүлээж авбал яах юм бэ гэдэг хариулттай зохицуулалтыг хууль гэж нэрлэж байгаа байхгүй юу. Түүнээс хүлээж авахгүй гэж тооцоо гаргачихсан хууль чинь өнөөдөр ингээд амьдрал дээр ийм асуудал гаргачхаад, Баасанжаргал гишүүн асуугаад хариулт байхгүй сууж байгаа. Байхгүй. Тэгэхээр энэ дээр бол дараагийн шатдаа энийг бид хийх ёстой. Би өөрийнхөө дараа гишүүд үг хэлж дууссаны дараа энэ дээр яг энэтэй холбогдуулж чиглэл өгөх үгүй бол ажлын хэсэгт шийдэл байхгүй. Энэ Байнгын хорооноос шүүхийн хараат бус байдлыг хангахад зориулагдаж тэр гарсан тэр хуулийн хэрэгжилтийг яг шууд хангах боломж байхгүй. Энэ нь алгасагдаад явчихсан байж байгаа. Өнөөдөр бид ийм хуультай байж байгаа юм. Тэгэхээр би энэ дээр нь нэмж чиглэл өгнө. Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Төсөвтэй холбогдуулж, Жавхлан сайд байж байгаарай энэ чинь бас гишүүд үг хэлэх байх. Тэгвэл тэр лүүгээ та орчхоод ирнэ биз.

Гэхдээ гишүүд чинь санаа оноо хэлнэ шүү дээ. Төсөвтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгнө үү? Эрдэнэболд гишүүнээр, Алтангэрэл гишүүнээр тасаллаа. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Би Ерөнхийлөгчийн хоригийг аваад, төсвийг буцааж байх дээр боловсрол, эрүүл мэнд, хууль сахиулах, шүүх эрх мэдлийн салбараас битгий танаач гэдэг зүйлийг гуйж байсан юм. Энэ зарчим бол хэзээд байх ёстой. Төсөв гэдэг бол нэг компанийн төсөв баталж байгаа юм шиг ашиг, алдагдлыг нь тэнцүүлээд ч юм уу тэр зүйл биш. Энэ чинь хүний эрхийг хангах бодлогын бичиг баримт юм. Энэ иргэдийнхээ эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах бодлогын бичиг баримт юм. Энэ эрүүл мэнд, боловсролын салбарын төсөв гэдэг бол Монгол Улсын хөгжлийн төсөв юм. Тэгээд энэ зүйлүүдээс ингээд хасаад, энэ байгууллагуудын салбарын үйл ажиллагаанууд доголдох энэ эрсдэл рүү орж байгаа нь туйлын харамсалтай байна.

Тэгээд би нэг зүйлийг хэлмээр байна. Ер нь хүүхдийн хүмүүжил түүнийг төрөхөөс 100 жилийн өмнө эхэлдэг гэж нэг Английн зүйр цэцэн үг байдаг юм байна лээ. Өөрөөр хэлбэл тэр хүүхдүүдийн орчин ямар байна түүнд л хүүхэд хүмүүждэг. Тэгэхээр энэ зүйлүүдийг сайхан болгоё гэвэл өнөөдрөөс эхлээд л энэ зүйлүүдээ хийж байх ёстой. Тийм учраас энэ хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаа гэдэг бол цаана нь гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх, хүний эрхийг хангах, шударга ёсыг тогтоох ийм зүйл байдаг. Тэгээд харамсалтай нь энэ дээр ингээд зарчим алдагдаад орж ирж байгаад туйлын харамсалтай байна. Тэгээд энийг тэгээд ажлын хэсэг нь ч гэсэн байгаа орон тоонуудыг нь хасаж байгаа юм байна. Энхийг сахиулах ажиллагаанд оролцох тоног, төхөөрөмжийн зардлаас нь хасагдчихаж байгаа юм байна. Эргээд энэ шаардлагатай тэр урсгал зардал болох бензин шатахуун, бичиг хэргийн зардлыг 50 хувиар таначхаж байгаа юм байна. Дуудлага мэдээлэл дээр хүрч чадахгүй. Тэр гэр бүлийн хүчирхийлэл тэр хаалганы цаана гэмт хэрэг болоод, дуудлага өгөхөд очиж чадахгүй, хэдэн цагийн дараа очих нөхцөл байдал руу орж байна. Энийг тэгээд бид хэд бодолцоно биз дээ.

Ер нь зүгээр ямар ч үед бол улс төржиж болно. Улс төрийн шийдвэр гаргаж болно. Тэгэхдээ хууль, эрх мэдэл, хууль сахиулах болон шүүх эрх мэдэл эргээд энэ боловсрол, эрүүл мэндтэйгээ ноцолдож хэдүүлээ хүрсэн үр дүнгээсээ ухарна гэдэг бол туйлын харамсалтай ийм зүйл болж байна. Тэгээд хэмнэж болох зардлууд байлаа. Яамнуудын чиг үүрэгтэй давхацчихсан үндэсний хороо, зөвлөл, комисс, төв, нэг баахан нэртэй хүмүүс. Би сүүлдээ Орон сууцжуулалтын бодлогын асуудлын хурдасгуур төв хийж байна гэж байгаа байхгүй юу. Аль сайд нь хариуцах гээд байгаа юм бэ? Эдийн засгийн хөгжлийн яам хариуцах гээд төлөвлөлтийн хувьд хийгээд байгаа юм уу? Орон сууцжуулалт, барилга, хотын яам хариуцах гээд байгаа юм уу? Эсвэл тэр 2 яамаа татан буулгаад, Хурдасгуур төв нь ажлаа хий. Наад захын л ерөөсөө жишээ энэ. Бид хэд ерөөсөө ингээд төрийн албаны босго давдаггүй хүмүүсийн ийм нэг үүрлэдэг газрыг бий болголоо.

2 дугаарт хэн хариуцлага хүлээх нь мэдэгдэхгүй ийм олон жижиг, жижиг төсвийн гадуур институтүүдийг бий болголоо. Наад захын ийм зүйлээс төсвийн хэмнэлт явах ёстой болохоос биш хууль сахиулах салбараас бол хэмнэлт хийж болохгүй. Энийг тэгээд бусад Байнгын хорооны, тэр ялангуяа Төсвийн байнгын хороо анхааралдаа аваач гэдэг зүйлийг би хэлмээр байна. Тэгээд би эцэст нь хэлье. Энэ хууль сахиулах салбар болон боловсрол, эрүүл мэндийн салбар бол энэ Монгол Улсын хөгжлийн төсөв байдаг юм шүү. Хүний эрхийг хангах төсөв байдаг юм шүү. Ийм зүйлээс бид хэд ухарч байгаад туйлын харамсалтай байна.

Д.Цогтбаатар: Эрдэнэболд гишүүн.

С.Эрдэнэболд: Тэгшитгэх гэдэг бол шударга ёсыг тогтоохгүй байгаад байгаа юм. Төсвөө танах ёстой юу гээд манай Улсын Их Хурал чинь хоригийг хүлээгээд авчихсан. Бүгдээрээ хасья, хасья гээд уралдаад ам уралдаад ярьсан. Хасахдаа яасан гэхээрээ тэгшитгээд хасангуут энд шударга ёсны зарчим алдагдаж байгаа юм. Тэгэхээр энэ чинь эргээд бүхэлдээ бид ингээд нөгөө туйлшрал руугаа л явж байна гэсэн үг. Энд байгаа ноцтой алдаа бол нөгөө би улиг болтол хэлээд байгаа. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцэж байгаа эсэхийг аудит хянах ёстой төсвөө. Энэ чинь яаж байна гэхээрээ зөвхөн цэрэг, цагдаа, мөрдөстэй генералуудын нууцын хавтас дотор байгаа бичгийн тухай яриагүй. Монгол хүний амь нас, эрүүл мэнд алдаж байгаа, эрх чөлөө хумигдаж байгаа, хүний эрх зөрчигдөж байгаа асуудал. Эдгээр асуудлуудыг шийдвэрлэх, хамгаалахад чиглэсэн төсвүүд танагдахгүй байх ёстой бөгөөд тэгээд энэ дээр нь эрүүл мэнд, боловсролын асуудал бас хамгаалагдах ёстой гэсэн энэ зарчмын үзүүлэлт.

Эцэст нь бол энэ priority буюу эрэмбийн асуудал явагдаад байгаа юм. Тэгэхээр өглөө Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороон дээр ч гэсэн аудитаас асуухад бас ингэж л хэлсэн. Одоо яамаар байна гэхээрээ ХЗБХ-ны даргад хандаж хэлэхэд бид энэ Үндэсний аюулгүй байдлын зөвлөл хуулиараа энэ шалгуур үзүүлэлтийг тогтоох ёстой юм байна лээ. Хэдий болтол бид ингээд төсөв дээр маргалдаж байх вэ. Энэ эрэмбийг тогтоохын тулд энэ шалгуур үзүүлэлтийг яаралтай гаргах ёстой юм байна.

Ерөнхийлөгч, Их Хурлын дарга, Ерөнхий сайд 3 Үндэсний аюулгүй байдлын зөвлөл гээд байж байгаа. Доороо ажлын албатай байгаа. Тэгэхээр энэ дээр Хууль зүйн байнгын хороо, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, холбогдох Байнгын хороонуудаас санал өгөөд, энэ шалгуур үзүүлэлтийг тодорхой болгомоор

байна. Тэгэхгүй бол Улсын Их Хурлын гишүүний утсанд мессеж ирж байгаа viber-аар. Юу гэж байгаа вэ гэхээрээ баахан байгууллагуудын дарга нараас захиас гуйлга, манай юмыг ингээд өгөөч гэсэн. Монголын төр ийм арчаагүй байж болохгүй шүү дээ. Миний утсанд гэхэд 10 гаруй мессеж ирж байна. Бүгдэд нь л ирж байгаа шүү дээ. Тэгээд төсвөө царайчилсан байдлаар, цаана нь байгууллагын бие даасан, хараат бус байдал, дээрээс нь шударга ёсыг тогтоох байдал хангагдахгүй шүү дээ. Тэгээд хэдэн Их Хурлын гишүүний аманд орно гэсэн үг шүү дээ. Энэ субъектив хандлагатайгаар төсвийг баталж болохгүй.

Тийм учраас сая асуулт эд нар асуухад та нар ч гэсэн зоригтой хэл л дээ. Тэгэхгүй тэгээд дүлгэнээд байх юм. Ерөнхийдөө нэг ийм нөгөө юу гэдэг билээ, нөгөө яалгуулж байхдаа таарсан гэдэг шиг. Тэгж болохгүй шүү дээ та нар зоригтой хэл л дээ. Та нар хувьдаа ийм юм гуйгаагүй, хууль ёсыг тогтоох, шударга ёсыг хамгаалах, сахиулахын төлөө үнэ төсөв чинь ийм болчихоод байна гэдгээ хэл л дээ. Улсын Их Хурлын гишүүд ч гэсэн энэ дээр байр суурьтай байх ёстой.

Тийм учраас одоо яах ёстой вэ гэхээр номер нэг асуудал бол тэр шалгуур үзүүлэлтээ тодорхой болгох ёстой. Яагаад ч хөндөж болохгүй, хэрхэвч хасаж болохгүй төсвүүдээ бид тэр тусдаа листэд оруулаад, харин тэр Сайнзориг гишүүний хэлээд байгаа тэр танаж хасах боломжтой төсвүүдээ хэдүүлээ зоригтой танаад хасаад явчих ёстой. Ийм л зарчмын байр суурьтай байна. Тэгээд энэ дээр бид нарыг лоббидох яах вэ, та бүхэн ч гэсэн энэ дээр дуу хоолойгоо нээлттэй илэрхийл. Ийм, ийм асуудал байна гэдэг зовлон, жаргалаа ярь. Олон нийт рүү ч гэсэн ярьж болно шүү дээ 1 дүгээрт.

2 дугаарт нь бид энэ төсөв гэдэг ойлголтыг энэ дагуулж орж ирж байгаа бичиг нь жишээлбэл 2025 оны төсвийг ямар бичиг баримт дагуулж орж ирж байна гэхээрээ 2025 оны хөгжлийн хөтөлбөр гэж орж ирж байгаа юм. Анзаараад байхад тэр хөгжлийн хөтөлбөр дээрээ ерөөсөө ач холбогдол өгөхгүй байгаад байгаа юм. Яг үнэн хэрэг дээрээ энэ төсвийг зохиоход чинь суурь болж байгаа бичиг баримт чинь тэр хөгжлийн хөтөлбөр. Тэр хөгжлийн хөтөлбөртөө хэний яанаагүй бүгдээрээ ач холбогдол өгөөд, тэр хөтөлбөрийнхөө, хөгжлийн хөтөлбөр чинь 4 зүйл явж байгаа шүү дээ. Одоо бид ямар байдлаар баталсан гэхээр 1-д эдийн засаг, 2-т бүсчилсэн хөгжил, 3-д Монгол хүн, 4-д Монгол хүний эрх чөлөө гээд баталчихсан байхгүй юу.

Тэгвэл Улсын Их Хурлаас 24-өөс 28 оны Стратеги, төлөвлөгөөнд чинь 1-д Монгол хүн буюу хүн төвтэй байна гээд баталчихсан шүү дээ. Тэгвэл одоо энэ шалгуур үзүүлэлт дээр тэр Их Хурлын стратегийг эшлээд ороод ирмээр байгаа байхгүй юу. 1-д нь Монгол хүн, 2-т нь эрх чөлөө, 3-д нь үүндээ зориулсан эдийн засаг, 4-д нь энэ рүүгээ чиглэсэн бүсчилсэн хөгжил ба бусад бодлогууд байна гээд оруулаад ирнэ. Тэр нөгөө.../минут дуусав/

Д.Цогтбаатар: 1 минут нэмээд өгчихье.

С.Эрдэнэболд: Анхнаасаа энэ чинь бид эрэмбээ буюу ач холбогдлынхоо дарааллыг зөв тогтоогоогүйгээс болоод энэ буруу явдал яваад байна. Одоо тэгэнгүүт ямар гаж үзэгдэл үзэгдэж байна гэхээр сая энэний өмнөх батлагдсан төсөв дээр нөгөө хоригт орсон төсөв дээр юу яригдсан гэхээрээ яамдын сайдууд манай энэ төсвийг үлдээчхээрэй, тойрог төлөөлж байгаа гишүүд манай энэ төсвийг оруулчихаарай, ийм улаан цагаан лобби явна. Өөрөөр хэлбэл хэн улс төрд

каризматик лобби ихтэй байна тэр хүн төсвөө хамгаалж үлддэг. Хэн гүйхгүй байна, хэн жоохон хойшоо сууж байна тэр нь бүтдэггүй ийм л байдалтай байгаа байхгүй юу.

Тэгэхээр Монголын энэ хууль, шүүх, энэ шүүхийг, шударга ёсыг хамгаалах гэж байгаа байгууллагууд Их Хурлын гишүүдээс төсвөө царайчилж биш, үндэслэл нотолгоогоо маш ойлгомжтой хийгээд, түүнийгээ хөдөлшгүй аргументаар хамгаалаад оруулж ирээд, батлуулдаг болмоор байна. Үүний төлөө хэдүүлээ явцгаая.

Д.Цогтбаатар: Тэмүүжин гишүүний микрофоныг өгье.

Х.Тэмүүжин: Эрдэнэболд гишүүний үгэн дотор хэд хэдэн удаа гарлаа. Үндэсний аюулгүйн үзэл баримтлалтай холбоотойгоор Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд төсөв хэлэлцэхтэй холбоотой эрэмбэ тогтоох гэх мэтчилэн. Бид хэд парламентын засаглал бүхий улсад амьдарч байгаа. Энэ эрх Улсын Их Хуралд өөрт нь байгаа. Бид өөрсдөө ажлаа хийх хэрэгтэй. Өөртөө байгаа эрх мэдлийг хэн нэгэн рүү сайн дураараа хадган дээр тавьж өгч ерөөсөө болохгүй.

Үнэхээр төсөвт хөдөлшгүй тодорхой эрэмбэ тогтоогоод, танахгүй гэж байгаа бол Улсын Их Хурал өөрөө дотроо яриад, жагсаалтаа гаргаад, энэ төсөвтэй холбоотой асуудал дээрээ цэгцтэй эрэмбэ тогтоож болно. Бид Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авсан, нэг алдаатай дүгнэлтийн араас жоохон хөөцөлдсөн. Төсөв алдагдалгүй байх тухай. Төсөв алдагдалгүй байх тухай биш, төсөв үр нөлөөтэй байх тухай бид ярилцах ёстой байсан. Өнөөдөр ХЗБХ-ны эрхлэх асуудлын хүрээн дэх агентлагууд сууж байна. Иргэнийхээ өмнө төр ийм чиг үүргүүдийг хэрэгжүүлнэ гээд хэнтэй ч булаацалдахгүйгээр, монополоор хэрэгжүүлдэг чиг үүрэг бүхий агентлагуудыг бид ХЗБХ ингээд эрхлээд сууж байгаа байхгүй юу.

Тийм учраас манай ХЗБХ-ны эрхэлж байгаа агентлагуудын төсөв алдагдалгүй байх тухай биш, үр нөлөөтэй байгаа юу гэдэг асуудлаа бид эхлээд ярих ёстой. ХЗБХ-ны эрхэлж байгаа агентлагуудаас төсөв танаж болно. Үр ашиггүй төсвүүд байгаа. Механикаар таначихаар цаана нь хүний эрх, цаана нь чиг үүргийн хэрэгжүүлэх үү, үгүй юү, хэрэгжүүлж чадах уу, үгүй юү гэдэг асуудал өөрөө хөндөгдөөд байгаа юм.

Би бол Аудит болон Хууль зүйн сайд, тэгээд Сангийн сайд байсан бол Сангийн сайд гэх мэтчилэн хүмүүст ХЗБХ-ноос бүүр чиглэл өгмөөр байгаа юм. Дараа нь энэ салбар луу таны гэж хэн нэгний хошуу орж ирэхгүй болтол нь бид төсөв зайлшгүй байх ёстой, үр нөлөөтэй байгаа гэдгээ батлах хэмжээнд жоохон хариуцлагатай баймаар байгаа юм. Манай агентлагуудын дотор үйл ажиллагаа явуулж байгаа албан тушаалтнууд дотор uniform буюу дүрэмт хувцас өмсөх шаардлагагүй албан тушаалууд зөндөө байгаа. Захиргааны албан тушаалууд. Тэд нартаа бид цолын нэмэгдэл, юу дүрэмт хувцас гээд маш үр ашиггүй өчнөөн мөнгө зарж байгаа юм. Тэгсэн мөртөө мөрдөн байцаалтад цаас хүрдэггүй, томилолт, хөдөө хээр дуудлагад явахаар бензин хүрдэггүй, машин механизм дутмаг гээд суугаад байгаа.

Дээр нь манай агентлагуудад дуучин, бөх ямар хэрэгтэй юм бэ, огт хэрэггүй шүү дээ. Социализмаас салаад энэ урлаг чинь иргэний болоод, ААН-үүд, хувийн хэвшил хийдэг болчихсон. Энэ нэг чуулгаасаа салаад, энэнийхээ зардлыг үндсэн

чиг үүрэг рүү оруулах цаг болсон шүү дээ. Дээр нь дахиад үнэхээр үндсэн чиг үүргүүд чинь юу юм бэ, тэр чиг үүрэг дээрээ төсвөө үнэхээр тоног, төхөөрөмжийнхөө хувьд, хүн хүчнийхээ хувьд хангалттай тавиад, чанартай үйлчилгээ үзүүлж чадна гээд иргэддээ амлалт өгөх цаг болсон. Тэгж байж бид татвар төлөгчдийн мөнгийг үр ашигтай зарцуулдаг, биднээс мөнгө танах харамлах хэрэггүй гэдэг нэр нүүртэй болох ёстой.

2-т нь дахиад би нэг зүйл дээр дахиад хариуцлагатай хэлмээр байна. Энэ төсвийн таналт дотор манай сургалт, тэмцээн уралдаан гэх мэтчилэн зүйлүүд танагдаж байгаа юм байна лээ. Энэ чиг үүрэг бүхий байгууллагууд, тэр дундаа хууль сахиулах чиг үүргийн байгууллагууд чинь яг ажил дээр гараад, ажлаа хийж байхдаа амь насаараа дэнчин тавьж ажилладаг байгууллага шүү дээ. Тэд нарын сургалтыг таначих юм бол нөгөө ажлын байран дахь нөхцөл байдал нь, нөгөө ажлаа хийх ур чадвар нь хойшоо сууна гэсэн үг. Тэд нарын дунд байдаг тэмцээн уралдаан, бэлтгэлийн зардлыг таначих юм бол сая онцгой байдлынхан харагдсан биз дээ. Газ дэлбэрэхэд газтай харьцах ямар ч мэдлэг байхгүй, тоног төхөөрөмж байхгүй, сургалт дадлага аваагүй байсан шүү дээ.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Нэмэлт 1 минут өгье.

Х.Тэмүүжин: Яг энэтэй адилхан гэмт хэрэгтэй тэмцээд, гэмт хэргийн халуун газар давхиад ордог, нэг бүрийн тусгай хэрэгсэл нь дутмаг, сургалт бэлтгэл хангагдаагүй. Хүний амийг хамгаалах битгий хэл өөрийнхөө амийг хамгаалах чадваргүй үсрэн орж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ чиг үүрэг дээр нь мөнгийг нь танадаг байж ерөөсөө болохгүй. Энэ чиг үүргийнх нь зардлуудыг харин ч нэмж өгч, сургалт, тэмцээн уралдаан, бэлтгэл хангах орон зайг тэлж өгөх ёстой.

Харин цаана нь байгаа юу гэдэг юм танаж болох зардлууд. Бидэнд бол энийг л танаж болж байна гээд одоо гаргаж хаяж, цэвэрлэж хаяад, энэнээс цаашаа орох ямар ч боломжгүй шүү гэж хилээ тогтоож авахгүй бол нөгөө захиргааны өөр бусад байгууллагатай адилхан механик таналт руу ордог болчихлоо. Механик таналтуудын ард чинь хүний амь байгаа. Механик таналтуудын ард хүний эрх, эрх чөлөө байгаа, өмч хөрөнгө байгаа. Механик таналтуудын ард хууль Монгол Улсад үйлчлэх үү, үгүй юу гэдэг ийм яриа байгаа шүү дээ. Тэгээд би энэ үгийг уг нь Сангийн сайдад зориулж хэлье гэж бодсон. Сангийн сайд гараад явчихлаа.

Д.Цогтбаатар: Гүйцээгээд хэлчих.

Х.Тэмүүжин: Төсвийн төлөвлөлт дээр Сангийн сайд, Сангийн яам ХЗБХ-ны эрхлэх асуудал бүхий яам, агентлагууд дээр тусдаа хандах ёстой шүү. Энэ агентлагууд, энэ яамны төсвийн таналтын ард чинь яг л амь насаа алдаж байгаа. Яг л хувь хүний эрх чөлөө, хувийн өмчтэй холбоотой энэ Монгол Улсын Үндсэн хуулийн байгуулал, хууль ёсны байгуулал оршин байгаа байх уу гэдэг асуудал яригдаж байгаа шүү. Энэ бол дарга нарын тансаглалын асуудал биш шүү.

Д.Цогтбаатар: Нөгөө хамгийн жинтэй, чухал үгээ хамгийн сүүлд нь оруулаад хэлчихээр нэмэлт цаг хугацаа өгөхгүй байх боломжгүй тийм сонголт үлдээлгүй үг хэлж байгаа байхгүй юу. Тэгээд нэмж үг өгч байгаа юм. Нарантуяа-Нара гишүүн микрофон өгье.

М.Нарантуяа-Нара: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгэхээр Улсын Их Хурал ч тэр, ЗГ ч тэр хүний эрхийг ерөөсөө оройн дээд оргилоо болгоно гээд Стратеги, төлөвлөгөөгөө боловсруулаад, зорилго зорилтоо болгоод оруулаад байгаа мөртөө яг энэ бодит тэр зүйлийг сахиулах, урьдчилан сэргийлэх, хамгаалах, хангах энэ бүх зүйлийг хамгийн анхдагч нэгж болсон жишээлбэл хүний эрх зөрчигдлөө гэж бодоход, мөн хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд хамгийн түрүүнд цагдаагийн байгууллага ажлаа хийдэг. Тэгсэн чинь ингээд цагдаагийн байгууллагаас маш их танаас орчихсон. Ерөөсөө энэ хууль хүчний байгууллагуудаасаа.

Тэгээд Засгийн газар 2019 оны тогтоол, судалгаагаараа энэ ажлын байрыг, орон тоог цагдаагийн албан хаагчийн, энэ цэргийн, цэрэг, цагдаа, дотоодын хүчний албан хаагчийн орон тоог 6000-аар нэмэгдүүлэх шаардлагатай гэж, нэмэгдүүлэх шаардлагатай гээд ингээд 25 оны төсөв дээр ингэж оруулж ирснээ энийгээ бүүр ингээд танаад хаячихдаг. Тэгэхээр нэг зүйл хэлмээр байгаа юм. Би бол яг амьдрал дээр тохиолддог асуудалд тулгуурлаад хэлмээр байна. Жишээлбэл цагдаагийн албан хаагч хүн харахад олон байна гэж шүүмжлээд байдаг. Гэтэл үнэндээ наад зах нь үе тэнгийнхний дээрэлхэл болоод 9, 10 настай хүүхдүүд хоорондоо үл ойлголцсон, магадгүй зодолдсон хэргээр үе тэнгийнхний бүлли боллоо гээд цагдаагийн газарт очиход хүүхдийн байцаагч гэж байдаггүй мэргэжлийн хүмүүс.

Ингээд орон тоо байхгүй учраас би ингээд байж байгаа юм гээд хүүхэдтэй харилцах ерөөсөө л эцэг хүний үүднээс л харьцаж байгаа болохоос биш яг хүүхдийн сэтгэл зүйг хангасан цагдаагийн албан хаагч гэж байхгүй. Гэтэл энэ нэмэгдүүлэх шаардлагатай энэ орон тоо дотор нь энэ хүүхдийн байцаагч, хүүхэдтэй ажиллах цагдаагийн нийгмийн ажилтан гээд зөндөө орон тоонууд ингээд байж байх ёстой байдаг. Гэтэл эд нарыг нь хэрэгцээгүй гээд танаад хаячихдаг.

Нөгөө талаар Түнхэл тосгоноороо жишье өөрийнхөө амьдардаг. Манай Түнхэл тосгонд 100 гаруй малчид эргэн тойрны 20км радиуст өвөлжөөндөө, малын өвөлжөөндөө ингээд гарчихсан байгаа. Жишээлбэл энэ айлуудад ямар нэгэн эрсдэл, асуудал болоод төвөөс дуудлага өглөө гэхэд бензин түлш нөгөө нэг юм нь өгөөгүй, төсвөөс гаргаж өгөөгүй, явах бензин түлш байхгүй, зардалд суугдаагүй. Тэгээд дээрээс нь энэ нөхцөл байдал зам харгуй нь энгийн нэг жижигхэн машин яваад очиход нэлээн хүндрэлтэй нөхцөл байдалтай.

Тэгээд одоо ингээд харахад цагдаагийн ингээд машин нь салж унах гэж байгаа нөхцөл байдалтай ийм байж байна. Нөхцөл байдлаа үнэлээд, шаардлагатай арга хэмжээнд тулгуурласан ийм үнэлгээ хийхгүй ерөөсөө тэр чигт нь ингээд хасаад хаячхаж байгаа нь бол маш буруу. Тэгэхээр Сангийн сайд энэ зүйлүүдийг маш сайн анхаараасай. Энэ зүйлүүдийг чадах чинээ боломжоор нь нэмээд шигтгээд суулгаасай гэж үнэхээр хүсэж байна.

Д.Цогтбаатар: Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: Бид чинь ч яах вэ Сангийн яам хэзээ ч байгаа гэж хэлдэггүй л дээ. Өмнөх төсвийнх дээр ч гэсэн байхгүй боломжгүй гээд байсан. Тэгээд батлаад өгсөн. Одоо дахиад хас гээд хориг авчихсан, тэгээд дахиад хасаад оруулж ирж байна. Тийм учраас энэ хасалт яаж орж ирсэн гэхээр Байнгын хорооны даргаа үндсэндээ Сангийн яамны хэдэн мэргэжилтнүүдийн хүрээнд бүх адилтгаад ингээд

хасчих гэдэг юм. Тэрнээс энэ агентлагуудын нягтлан, дарга нарын саналыг сонсоод ингэж оруулж ирж байгаа юм ерөөсөө байхгүй байгаа шүү дээ. Автоматаар нэгдсэн байдлаар шууд адилтгаад хасчхаж байгаа юм. Тийм учраас хасаж болох зардал байна, хасаж болохгүй зардал байна. Тийм учраас энэ цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэл гээд энэ онцгой хүний амь нас, эрүүл мэнд, нийгмийн дэг журам сахиулах чиг үүрэг бүхий байгууллагуудын энэ унаа машин, бензин шатахуун, томилолтын зардлыг хэзээ ч хасаж болохгүй. Дараа нь бид манай ХЗБХ энэ байгууллагуудаас юу шаардах юм, юу нэхэх юм.

Тийм учраас юу гэж хэлэх гэж байна вэ гэхээр Байнгын хорооны дарга ер нь бол энэ Байнгын хорооны хурлын дараа энэ байгууллагуудын нягтлан, дарга нарыг тусад нь авч үзэж сууж байгаад, яг томилолт юмнуудынхаа, бензин шатахууныхаа зардлуудыг тусад нь гаргаж ирээд хасуулахгүй байх чиглэлийн юмнуудыг нэгтгэж байгаад, энэ Байнгын хорооны даргын хувьд энэ төсвийн ажлын хэсгийнхэнтэй уулзмаар байна. Төсвийн ажлын хэсгийнхэнтэй энэний дараа. Тэгээд манай эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын огт хасаж болохгүй зардлуудыг бид дахиж авч үзэж байгаад ийм хэмжээний зардал. Одоо бол энэ чинь манай эрхлэх асуудлын хүрээнээс 60 тэрбумыг хасчхаад байна шүү дээ. Тэрний 57 нь ХЗДХ-ийн сайдын төсвөөс. Тийм учраас энэ төсвүүд дээр бас дотор нь хасаж болох, хасаж болохгүй зардлуудыг ялгаж үзэж байгаад, Байнгын хорооны хурлын дараа дахиж энэ агентлагийн дарга нартай сууж байгаад нэг харж үзье. Асуудлын ярьж байгаад, ажлын хэсэгт энэ саналаа оруулж, хамгаалж авч гармаар байна Байнгын хороон даргаа.

Тэгээд дандаа төсөв дээр жил болгон ингээд нэг гуйлгачин царайлаад ЗГ-ыг аргадаад, гуйгаад, тэгээд өгөөч, ингээд өгөөч, тавиад өгөөч гээд ингээд гуйж байдаг. Эцсийн эцэст Улсын Их Хурал чинь төсвөө батлах бүрэн эрх нь гишүүдэд байдаг биз дээ. Тэгчхээд Сангийн сайдыг оруулж ирсэн төсвөөр нь ингээд л, сая бид түүхэндээ анх удаа Сангийн яамны өргөн барьсан төсвийг ямар ч өөрчлөлтгүйгээр батлаад өгөөд явуулсан. Тэр нь өөрөө буруудаад явж байгаа шүү дээ. Тийм учраас ахиж энэ дээр сууж, бүүр ахиж нарийвчилж үзэж, энэ агентлагуудын дарга нар, нягтлангуудыг яах гэж оруулж ирсэн юм. Тийм учраас саналуудыг нь ялгаатай авч үзээд, томилолт, бичиг хэргийн зардлуудыг нь хасаж болохгүй. Тэр зардлуудыг нь ялгаж оруулж ирээд, ингээд нэг хамгаалж авч үлдэх асуудлыг Байнгын хорооны даргын хувьд энэ төсвийн ажлын хэсэг дээр ярилцаач гэж би хэлэх гэж байна. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Алтангэрэл сайдын микрофоныг өгье. Манай Байнгын хорооны гишүүн биш ч гэсэн энд үгээ хэлэх эрхтэй, Улсын Их Хурлын аль ч гишүүн.

О.Алтангэрэл: Манай энэ салбарын байгууллагуудын үйл ажиллагааг ойлгож, дэмжиж байгаа гишүүддээ баярлалаа. Дэмжиж үг хэлж байгаа, санал гаргаж байгаа гишүүддээ маш их талархаж байна.

Хэд хэдэн зүйлүүдийг бид ерөөсөө ярихгүй бол болохгүй байгаа юм. Цагдаагийн байгууллагын хувьд бол сая асуудал яригдлаа. 6 мянга гаруй орон тоо дутуу байгаа гээд. Манай хүн ам өсөөд байдаг, нягтрал нэмэгдээд байдаг, тэр тоолонгоор Цагдаагийн албан хаагчдын орон тоо нэмэгдэх ёстой. Тэгээд энэ орон тоо нь 6 мянга гаруй больё, 2 мянга байя гэсэн. Сангийн яаман дээр очоод талыг нь хассан. Сая бас энэ Төсвийн ажлын хэсэг гээд тэрийг маань бүүр ингээд юу ч

үгүй болгоод, хасаж байгаа сурагтай байна. Энд бол их харамсаж байгаа юм. Ерөөсөө санаанаасаа зохиогоод юм уу нэмчихсэн нэг ч зүйл байхгүй.

Уг нь бол албан хаагчдын орон тоо ийм хэрэгтэй байгаа. Хил хамгаалахын нөхцөл байдал, бид ер нь хойд хөрштэйгөө холбоотой нөхцөл байдлын улмаас бид хил хамгаалах байгууллага бол орон тоогоо бас нэмбэл нэммээр байгаа. Тэгээд энэ дээр бол нэг их айхтар орон тоо нэмэгдэл бид тавиагүй. Тэгээд хамаг боломж бололцоогоороо уг нь оруулж ирсэн, ингэчихлээ.

Тэгээд жишээлбэл Монгол Улсын экспортын гол суваг болсон Цагаан хадан дээр гэхэд тэр олон мянган машин, жолоочид төрийн захиргааны нэгж байхгүй байхад хэдэн гэрээт цагдаа нар тэнд зохицуулаад зогсож байгаа байхгүй юу. Тэгээд энэ Монгол орон даяар үйлдэгдэж байгаа гэмт хэргүүдийн эсрэг цагдаа л явж байна. Усны объектууд хүн амын амь нас, эрүүл мэндтэй холбоотой хамгаалалтад дотоодын цэрэг л зогсож байна. Тэгсэн мөртөө яг энэ хүмүүсээ үздэг Төрийн тусгай албан хаагчдын эмнэлгийнхээ хүртэл зардлыг таначихсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хувьд нэг онцлогтой юм байгаа юм. Энэ шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиар бид энэ он гараад баривчлах шийтгэл оногдуулсан этгээдүүдийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага өөрсдөө энэ шийтгэлийг эдлүүлэхээр шилжүүлж авна. Тэгээд хэрвээ энэ төсөв дээрээс энэ шийдвэр гүйцэтгэх байгууллагын орон тоо хасагдах юм бол үндсэндээ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага энэ үүргээ гүйцэтгэж чадахгүй. Шууд хуулийг хэрэгжүүлж чадахгүй доголдол үүсэж байгаа юм.

Түрүүн тэр энхийг сахиулах ажиллагаанд ярьж байна 7 тэрбум төгрөг хасчихсан. 20 хувь гээд шууд хасчхаж байгаа юм. 20 хувь байтугай 2 хувь хасахад энхийг сахиулах ажиллагаанд оролцоход доголдол үүснэ. Зөвхөн техник хэрэгсэл, тэр хуягласан болоод элдэв янзын тусгай зориулалтын техник хэрэгсэл гэхэд 46 тээврийн хэрэгсэл байгаа шүү дээ. Тэгээд бусад дагалдах зүйлүүд нь ийм байгаа юм. Тэгэхээр гишүүдээсээ нэг зүйлийг хичээнгүйлэн хүсье. Цогтбаатар даргаасаа, Цогтбаатар даргаа би бас яг Сандаг-Очир гишүүнтэй адилхан хүсэлт байна.

Энэ төсвийн ажлын хэсэг гээд хүмүүс сууж байгаад яг Сангийн яам энэнээс нь 20 хувь, энэ муу дотоод томилолтыг нь хасчихъя, бичиг хэргийг нь хасчихъя гээд байгаа, хамгийн их цаас үйлдвэрлэдэг, хамгийн их дотоод томилолтоор явдаг энэ нэгжүүдийн үйл ажиллагааг хассан шиг, шууд тэр ажлын хэсэг дээр ярьж байгаа зүйлийг нь сонсохоор тэдэн хувь хасчихъя энэ орон тоо их байна, цагдаагийн нэмэгдэж байгааг бүгдийг нь 100 хувь хасъя, шийдвэр гүйцэтгэлийг хасъя гээд ингээд шууд тэр үнийн дүнг нь хараад хасаад байна гэж байна. Тэгэхээр ХЗБХ маань энэ асуудалд анхаарал хандуулж өгөөч 1 дүгээр хүсэлт.

2 дахь хүсэлт нь хэрвээ манай энэ тавьсан орон тооноос хасаж байгаа бол тэр орон тооны чинь урсгал зардал нь гарч ирнэ. Тэгээд энэ зардлыг тэр хүмүүсийг хэмнэж байгаа гэж үзэж байгаа зардлыг саяын манай гишүүдийн гаргадаг, манай Сандаг-Очир гишүүний хэлж байгаа тэр дотоод томилолтын зардал, бичиг хэргийн зардалд, манай цагдаагийн байгууллагын энхийг сахиулах үйл ажиллагаанд дэмжих зардал гээд энэ зардлуудад буцааж.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Гишүүд үг хэлж дууслаа. Тэгэхлээр би энд нэг хэдэн зүйл яримаар байна. Би гишүүдийнхээ гаргаж байгаа саналтай яг санал нэг байна. Тэгэхээр бид нарын урьд нэг ийм асуудал байна. Түр завсарлаад, ялангуяа ажлын хэсэгт орж ажилласан гишүүд Номинчимэг гишүүн, Алдаржавхлан гишүүн аль алинаас бид хасаад, хаашаа нэмэх вэ энийгээ эсхүл шууд тодорхой яриад, зарчмын зөрүүтэй санал хэдүүлээ оруулж нэг болж байна. Эсхүл манай Байнгын хороо бид суугаад энийгээ ярьж болно шүү дээ. Тийм. Тэгж нэг болж байна.

Яагаад гэвэл тэгэхгүй бол энэ манай Байнгын хорооны нөгөө хуулиар олгогдсон эрх алгасагдаж явчхаад байгаа байхгүй юу. Тэгээд энийг чинь одоо зүгээр ингээд явуулчихаар нээрээ яг саяын ярьсан асуудлууд үүсэж байгаа юм. Зарчмын зөрүүтэй санал байвал одоо бид тэгэхээр түр завсарлаж байгаад гаргаж болж байна. Эсхүл бид яах вэ чиглэл өгөөд явуулчхаж болно. Яг үнэндээ иймээрээ бид хүлээж авч болохгүй. Хэрвээ ажлын хэсэг цаанаа илүү ажиллаад, янзлах тэр боломж байж байгаа бол бид энэ, би үгээ хэлээд дуусгаадахъя.

Тэгэхээр энэ дээр бид энэ саналаа гаргаж өөрчлөх ёстой гэдэг байр сууриа би дараах хэдэн зүйлээр үндэслэмээр байгаа юм. Хууль дээдэлнэ гэж яриад байгаа. Хууль дээдлэх зарчим бол тэрэнд нь тавигдаж өгөх ёстой төсвийг тавьснаар л эхэлнэ. Түүнээс хүмүүсийг энэ дээр Их Хурлаас загнаад ажлаа хий, төсөвгүй ч байсан хий гэж хууль хэрэгждэггүй. Энэ бол зүгээр худлаа мөрөөдөл. Ингэж загнана гэдэг бол шоу. Хүний эрх хамгаална гэж байгаа юм бол тэр мөнгийг нь тавьж өгөх ёстой.

Тэгээд би нэг зүйлийг хэлмээр байгаа юм. Төсөв хянаад ингээд алдагдалгүй болгоод оруулаад ир гэсэн чинь ямар төсөв оруулж ирж байна гэхээр та нар яасан их хянаж багасаг гэдэг юм, май та нар гэсэн шиг бүгдийг нь танаад оруулж ирж байгаа байхгүй юу. Тэгэхээр сургууль, цэцэрлэгээс, цагдаа, шүүхээс танах боломжгүй шүү дээ. Энэ чинь зайлшгүй байх ёстой энэ салбарууд байхгүй юу. Тэгээд би нөгөө түрүүний Байнгын хорооны хурал дээр ч хэлж байсан. Жишээлбэл шүүх бол Үндсэн хуульд заагдчихсан институт. Энэ 23, 4 яам чинь Үндсэн хуульд байхгүй. Тэрний тал нь байх шаардлагагүй яамнууд байхгүй юу. Тэндээс яагаад танахгүй байгаа юм бэ? Бүгдийг нь жигд танаад оруулж ирсэн. Байх шаардлагагүй Үндсэн хуульд угаасаа заагдаагүй зөндөө газраас хасах боломж байгаад байхад ингээд жигдэлж хасна гэдэг бол өөрөө яах аргагүй гарах ёстой энэ асуудлыг гаргаад байгаа юм.

Пүрэвдорж гишүүн ч гэсэн хүндэтгэх шалтгаантай эмнэлэгт үзүүлээд явж байгаа гэхэд над руу утасдаад л энэ цагдаа, хууль хүчний байгууллагуудын юун дээрээс чинь хамаагүй хасчихсан байна шүү дээ гээд. Энэ дотоодын цэрэг дээр жишээлбэл усны эх үүсвэрийг хамгаалж байгаа улсууд чинь хамгаалах ёстой. Өөр ямар ч сонголт байхгүй шүү дээ. Тэгж байж бид крантаасаа, зүгээр энгийн крантаа онгойлгоод ус хийгээд, буцалгаад ууж байгаа бол тэр чинь аюулгүй байна гэдэг баталгаа чинь тэндээс эхэлж байгаа. Тэрийг чинь хэн нэгэн хүн хангаж байгаа. Түүнээс байгалиас заяагдаад ороод ирчхээд байгаа юм биш. Өнөөдөр крантаараа авч ууж байгаа усыг би ярьж байна шүү дээ. Тэгэхээр энэ дээр бол бид энэ бүх юмнуудаа эргэж харах хэрэгтэй байна. Горимын санал Алдаржавхлан гишүүн яг үнэн ажлын хэсэгт орж ажиллаж байсан хүний хувьд саналаа хэлэх үү.

Ж.Алдаржавхлан: Ажлын хэсэг ажиллаж байгаа. Одоо бид 4 цагаас дахиад хуралдаад, ажлуудаа ярина. Энд, тэнд сонсохоор бас нээрээ ч тийм юм шиг

сонсогдоод л, энд та бүгдийн зовлонг сонсохоор бас аргагүй ч юм шиг сонсогдож байгаа байхгүй юу. Тэгэхээр яг Сандаг-Очирын хэлдгээр үнэн, ажлын хэсэг дээр Байнгын хорооны дарга түр хурлаа завсарлуулаад, түр хойшлуулаад, тэгээд ажлын хэсэгтэйгээ ойлголцохгүй бол тэнд нэг том шийдвэр гарчихна. Тэгээд Их Хурал 2 хуваагдаж байгаа ч юм шиг асуудалд орно шүү. Тийм учраас би таны тэр саналыг гаргаад дэмжиж байна. Энэ хуралдаанаа түр завсарлуулаад, тэгээд ажлын хэсэг энэ тэр хуралдсаны дараа дахиж үргэлжлүүлээд, тэр зарчмын зөрүүтэй санал энэ тэрээ гаргахгүй бол энд нэг баахан санал хураачихдаг, тэнд очоод уначихдаг.

Тэгээд энд нэг баахан сайхан, сайхан юм ярьж байгаад, тэгээд гараад ирсэн та бүгдийн бүх төсөв хасагдчихсан явж байдаг. Тийм байж болохгүй байх. Тийм учраас Цогтбаатар даргаа хурлаа түр хойшлуулаад, ажлын хэсэгтэй та ажлын хэсгийн хуралдаан дээр уулзалдаад, тэгээд нэг тийш нь болгохгүй бол Их Хурал дээр 2 янзын шийдвэр 2 талд гарах вий дээ. Тэр цагдаагийн асуудал бүх түвшинд яригдаж байна лээ. Тэнд ярьж байгаа хүмүүсийг сонсохоор нээрээ аргагүй ч юм шиг, та бүгдийн энд ярьж байгааг сонсохоор үлдээх ёстой ч юм шиг байна шүү дээ. Тийм учраас энэ зовлонг нь аваачиж тэр хүмүүс сонсох ёстой юм. Шалтгааныг нь ярихгүйгээр бид асуудал шийдэж чадахгүй шүү дээ. Тийм учраас би таны тэр гаргаж байгаа саналыг дэмжиж байна. Түр хуралдаанаа хойшлуулаад, хэдүүлээ ярилцаад, үргэлжлүүлье гэсэн бодолтой байна.

Д.Цогтбаатар: Ингэе, тэгвэл ерөөсөө маш тодорхой цагдаа, дотоодын цэрэг, шүүх дээр, шүүхийн шийдвэр дээр саналуудаа хэдүүлээ нэгтгэе гэсэн ийм томъёололтойгоор, тийм Шүүхийн ерөнхий зөвлөлтэй, томъёололтойгоор би хурлыг завсарлуулж байна. Тэгээд энэ дээр саналуудаа томъёолж оруулж ирээд, хурлыг эргээд хуралдуулж явуулъя.

Хуралдаан 16 цаг 21 минутаас 17 цаг 49 минутад түр завсарлав.

Д.Цогтбаатар: Гишүүд орж ирж, хуралдаа суугаарай. Энэ ХЗБХ-ны 2024 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаа үргэлжлүүлье. Түрүүн түр завсарлуулсан байгаа. Ингээд гишүүд зарчмын зөрүүтэй төсвийн асуудлаар манай Байнгын хорооны хамрах хүрээний асуудлын хүрээнд зарчмын зөрүүтэй асуудлаараа тохиролцоонд хүрсэн байна. Ингээд гишүүдээс зарчмын зөрүүтэй саналуудыг сонсоод, үүгээр тус бүрээр нь санал хураана. Хамгийн эхлээд Нарантуяа-Нара гишүүнд микрофон өгье. Зарчмын зөрүүтэй саналаа уншиж танилцуулаарай.

М.Нарантуяа-Нара: Тэгэхээр энэ Хууль зүй, дотоод хэргийн яам дотроо шилжүүлэг хийх ийм зарчмын зөрүүтэй санал гаргасан байгаа. Тэгэхээр нөгөө зардал бууруулах төсөл, хөтөлбөр, арга хэмжээ дээр цагдаагийн байгууллага, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Дотоод хэргийн их сургуулийн 2025 онд нэмэгдэх орон тоог 30 хувиар бууруулах, буурч байгаа орон тоотой холбоотой урсгал зардлыг холбогдуулан бууруулах замаар Хууль зүй, дотоод хэргийн сайдын урсгал зардлыг бууруулах ийм юу зарчмын зөрүүтэй санал гаргаж байгаа.

Нэрээр нь уншъя. Монгол улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын Хууль зүй, дотоод хэргийн сайдын 11.1, 11.2, 11.3, 11.4, 11.5, 11.6 дахь хэсгийн тоног, төхөөрөмж хэсгийн төсөвт өртөг баганын 2025 онд багана болон

2025 онд санхүүжих дүн баганын дүнг харгалзуулан нийт 21,2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх ийм зарчмын зөрүүтэй санал гаргаж байгаа юм.

Д.Цогтбаатар: Энэ зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулна. Гэхдээ түр хүлээж байгаарай. Саяын уншсан зарчмын зөрүүтэй саналаар. Ингээд энийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 62,5 хувиар санал дэмжигдлээ. Дараагийн зарчмын зөрүүтэй санал Сайнзориг гишүүн гаргана. Сайнзориг гишүүн саналаа танилцуулъя.

П.Сайнзориг: 1 санал гаргая. Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын хөрөнгө оруулалт, их засварын зардлаас 9,8 тэрбумаар бууруулаад Хууль зүй, дотоод хэргийн яамны норматив зардлыг мөн дүнгээр нэмэгдүүлэх гэсэн зарчмын зөрүүтэй саналыг гаргаж байна. Байнгын хорооны гишүүдийг дэмжиж өгөхийг хүсье.

Д.Цогтбаатар: Саяын уншиж танилцуулсан зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 56,3 хувиар санал дэмжигдлээ. Дараагийн зарчмын зөрүүтэй саналыг Баасанжаргал гишүүн гаргана.

Х.Баасанжаргал: Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн санхүүжилтийг 991 сая төгрөгөөр бууруулж, Авлигатай тэмцэх газрын томилолтын зардал 533,2 сая төгрөг, хангамж, бараа материалын зардал 112,6 сая төгрөг, хөрөнгийн зардал 345,4 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн ийм санал гаргаж байна.

Д.Цогтбаатар: Энэ уншиж танилцуулсан томъёоллоор дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 62,5 хувиар санал дэмжигдлээ. Дараагийн саналыг Баасанжаргал гишүүн гаргана.

Х.Баасанжаргал: Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн санхүүжилтийг 620,5 сая төгрөгөөр бууруулж, Монгол Улсын Ерөнхий прокурорын томилолт, зочны зардал 420,5 сая төгрөг, бичиг хэргийн зардал 200,5 сая төгрөгөөр нэмэгдүүлэх, 200,5 сая. Цахим хөгжил, инновац, сайдын Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангаас 620 сая төгрөгөөр хасаад гэсэн үг. Дэмжээд өгөөрэй.

Д.Цогтбаатар: Энэ саяын уншсан томъёоллыг дэмжье гэж санал хураалт явуулъя. 56,3 хувиар саяын санал дэмжигдлээ. Эрдэнэболд гишүүн зарчмын зөрөөтэй санал гаргана.

С.Эрдэнэболд: Хууль зүй, дотоод хэргийн сайдын дараах урсгал зардлыг нэмэгдүүлэх зарчмын зөрүүтэй саналыг гаргаж байна. Үүнд 4 хэсэг байгаа. 1 дүгээрт Цагдаагийн ерөнхий газрын томилолт, бичиг хэргийн зардал 2 тэрбум 900 сая төгрөг, 2 дугаарт Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын томилолт, бичиг хэрэг 245 сая төгрөг, 3 дугаарт Хил хамгаалах ерөнхий газрын байр ашиглалтын зардал 1 тэрбум төгрөг, 4 дүгээрт Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн татаас санхүүжилт 920 сая төгрөг нийт 5,6 тэрбум төгрөгийг Сангийн сайд, Сангийн яамны хөрөнгө оруулалт, их засварын зардал 107,6 тэрбум төгрөгөөс гаргуулах зарчмын зөрүүтэй саналыг гаргаж байна. Саяын уншиж танилцуулсан томъёоллыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Тэгвэл тэгээд саяын санал бол унаж байна шүү дээ. Тийм саяын саналаа, уг нь.

Уянгахишиг гишүүн тэгвэл санал, тэгвэл ингээд саяын санал уналаа шүү. Уянгахишиг гишүүн зарчмын зөрөөтэй саналаа танилцуулъя.

Г.Уянгахишиг: Шүүхийн ерөнхий зөвлөлийн хөрөнгө оруулалтын төсвөөс дахиад 4 сая, 4 тэрбум төгрөг хасагдчихсан байгаа. Энийг буцааж оруулах оруулах буюу Шүүхийн ерөнхий зөвлөлийн хөрөнгө оруулалтын зардлыг 4 тэрбум төгрөгөөр, 4 тэрбум 55 сая төгрөгөөр нэмэгдүүлэх, энэ эх үүсвэрийг болохоороо Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын хөрөнгө оруулалтын зардлыг бууруулах замаар.

Д.Цогтбаатар: Одонтуяа гишүүн үг хэлье. Одонтуяа гишүүнээ энэ дээр нээрээ уучлаарай, санал гаргаж байгаа гишүүн л тайлбараа хэлнэ шүү дээ. Уянгахишиг гишүүний микрофоныг өгье.

Г.Уянгахишиг: Энэ дээр нөгөө нэг их айхтар уг нь нам ч гээгүй юм л даа. Юун дээр хөрөнгө оруулалт, их засварын зардал дээр 127 тэрбум төгрөг байгаа байхгүй юу. Тэгэхээр тэр дундаас 4 тэрбум төгрөгийг ямар ч байсан, өмнө нь бид зөндөө ярьсан. ШЕЗ-ийн хөрөнгө оруулалт гээд ХЗБХ дээр 100 хэдэн тэрбумаар, 120 хэдэн тэрбумаар билүү байсныг буцаагаад өмнөх төсөв батлагдахдаа дахиад 60 хэдэн, 67 тэрбум болгоод буулгачихсан шүү дээ. Тэгээд төсөв маань хүчингүй болсны дараа буцаж орж ирэхдээ дахиад 4 тэрбумаар хасаад ороод ирж байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг ер нь бол зарчмын хувьд яг энэ хасагдах ёстой зардал биш. Өөрөөр хэлбэл танах ёстой тэр нөгөө тэвчих боломжтой зардал гэж үзэхгүй байгаа байхгүй юу.

Тийм учраас энийг бол буцааж оруулах ёстой буюу анхны хүчингүй болсон төсөв дээр байсан 67 тэрбумаараа байх ёстой гэдэг зарчмын хувьд энэ 4 тэрбумаар нэмэх саналыг гаргаад байгаа юм шүү.

Д.Цогтбаатар: Зөв, зөв. Угаасаа энэ чинь ингээд хавтгайд нь хядаад ерөөсөө буулгаад оруулаад ирж байгаа нь ялангуяа хууль зүйн салбарын энэ хууль зүйн салбарт бол байж болохгүй зүйл шүү дээ. Яалт ч үгүй. Тэгэхээр энэ дээр гишүүдийн гаргаж байгаа би саналыг хүндэтгэж үзэж байгаа. Ингээд саяын энэ уншиж танилцуулсан саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Тийм байна. Өөрөө, тэгье. Тэгвэл горимын саналаа гаргачих.

Г.Уянгахишиг: Энэ сая миний төхөөрөмж ажилласангүй. Нөгөө алдаа заачихлаа. Тэгэхээр саналыг энэ саяын саналыг хүчингүй болгох горимын санал гаргаж байна.

Д.Цогтбаатар: Энэ саяын саналыг хүчингүй болгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Саяын тэгвэл санал уналаа. Тэгвэл одоо яая гэх вэ үүгээрээ тэгээд ХЗБХ саналаа гаргаад явуулж байна. Санал хураалт явуулж дууслаа. Дагасан хуулиуд байгаа шүү, манайхан 2 дахь асуудал байгаа шүү. Төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаар ХЗБХ-ноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулна. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

18.10 цаг

Хоёр.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

2 дахь асуудалдаа орёе. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, Засгийн газарт чиглэл өгөх тухай, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье. Монгол Улсын төсвийн, улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье. Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрээ өгнө үү? Алга байна. Зарчмын зөрүүтэй саналгүй. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрээ өгнө үү? Алга байна. Зарчмын зөрүүтэй саналгүй. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Монгол Улсын төсвийн 2025 оны төслийн төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн, төслийг зүйл бүрээр хэлэлцье. Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрээ өгнө үү? Алга байна. Зарчмын зөрүүтэй саналгүй. Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрээ өгнө үү? Алга байна. Зарчмын зөрүүтэй саналгүй. Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрээ өгнө үү? Алга байна. Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрээ өгнө үү? Алга байна. Зарчмын зөрүүтэй саналгүй. Түрүүний юун дээр бас зарчмын зөрүүтэй санал байгаагүй. Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрээ өгнө үү? Алга байна. Зарчмын зөрүүтэй саналгүй. Монгол Улсын төсвийн, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг зүйл бүрээр нь хэлэлцье. Тогтоолын төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрээ өгнө үү? Алга байна. Зарчмын зөрүүтэй саналгүй. Тогтоолын төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрээ

өгнө үү? Алга байна. Зарчмын зөрүүтэй саналгүй. Тогтоолын төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Зарчмын зөрүүтэй саналгүй. Тогтоолын төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Зарчмын зөрүүтэй саналгүй. Тогтоолын төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Зарчмын зөрүүтэй саналгүй. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг зүйл бүрээр нь хэлэлцье. Тогтоолын төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Зарчмын зөрүүтэй саналтай гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Зарчмын зөрүүтэй саналгүй. Тогтоолын төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Зарчмын зөрүүтэй саналгүй. Тогтоолын төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Зарчмын зөрүүтэй саналгүй. Тогтоолын төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Зарчмын зөрүүтэй саналгүй. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийлээ.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, Засгийн газарт чиглэл өгөх тухай, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаар ХЗБХ-ноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Алдаржавхлан төсвийн, хэн гэсэн бэ? Заяабал гишүүн Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулна.

18.16 цаг

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Гишүүдэд баярлалаа. Тэгвэл өнөөдрийн хурал ингээд дуусаж байна.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.УЯНГА